



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
НЯМ-ОСОРЫН УЧРАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025.12.18 № 31-1/140
танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл
өргөн мэдүүлэх тухай

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР

• 000254006228



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201

Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,

Цахим шуудан: info@cabinet.gov.mn,

Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.12.18 № 1297/3556
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт ⁷⁵ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“З.ХЭЛЭЛЦСЭН нь: “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>


2025.12.17 № 01/10993

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА С.БЯМБАЦОГТ ТАНАА**

“Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2025-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761002361



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,


Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.12.17 № 112799

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ
ТАНАА**

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.


Б.ЭНХБАЯР

А5.файл.2025
151802334



Огноо: 2025.12.17

**“ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХУВЬЦААГ 2026-2028 ОНД
БИРЖЭЭР ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХУДАЛДАХ, ТӨРИЙН ӨМЧИЙГ
ХУВЬЧЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж, Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ” гэж тус тус хуульчилсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад “Улсын Их Хурал төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл, хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг батлах, түүнд өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй” гэж заасан.

Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжина” гэж заасан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтад Засгийн газар “чиг үүргийн давхардалтай, эсхүл чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх зэргээр удирдлагын зардлыг хэмнэх” арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны Ухаалаг засаглалын зорилгын 5.2.19-д “Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дугаар тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023–2030 он/-ийн Зорилт 8.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит компани, түүний охин компанийг үүсгэн байгуулах, татан буулгах, бүтцийн өөрчлөлт хийхэд мөнгөн урсгал, техник, эдийн засгийн үндэслэл, улсын төсөвт төвлөрүүлэх татвар болон судалгаа, дүн шинжилгээнд тулгуурладаг байна. Алдагдалтай ажилласан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын шалгалт хийж, үндэслэл, шалтгааныг тогтоож, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2.4-т “төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ” гэж, 3.3.3.1-д Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлах, эрчим хүчний салбарыг чөлөөт зах зээлийн зарчимд шилжүүлж, үнэ тарифыг зохистой түвшинд хүргэн, цаашид тогтмол индексжүүлэх тогтолцоог нэвтрүүлж, салбарын эрх зүйн орчныг шинэчилнэ” гэж, 4.1.4.2-т “төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагааг явуулах тогтолцоог бүрдүүлэх...” гэж, 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэсэн зорилтыг тус тус дэвшүүлсэн.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 52 дугаар тогтоолын 2 дахь заалтын 3 дахь дэд заалтад төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах асуудлын талаар холбогдох санал боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

“Шинэ итгэл-Эрс шинэтгэл” “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд төрийн өмчит компанийн засаглалыг олон улсын компанийн засаглалын зарчимд нийцүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх, Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны бүртгэл, мэдээллийн ил тод байдлыг бүрэн ханган төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалтын цахим шилжилтийг хийх зорилтыг тусгасан.

1.2. Нөхцөл байдал, практик шаардлага

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах хүрээнд төрийн өмчит компанийн үр ашгийг нэмэгдүүлэх, олон нийтийн хяналтад оруулж, санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангуулах болон төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог бууруулах зорилгоор хувьчлалыг үр дүнтэй зохион байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийг нээлттэй хувьцаат компани болгох, хувьцааг нь биржээр олон нийтэд нээлттэй худалдах, өөрчлөн зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн өмчийг

хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг тогтоох шаардлагатай байна.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу төрийн нийтийн өмч, түүний төрөл, зүйлийг тодорхойлох, өмчийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийг шинэчлэх, өөрчлөлт оруулах замаар хэрэгжүүлэх бөгөөд үүнтэй уялдуулан төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл тогтоох асуудлыг өнөөгийн нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлага, бизнесийн орчин нөхцөл болон олон улсын сайн туршлага, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) зэрэг холбогдох бусад байгууллагын судалгаа, зөвлөмжид тулгуурлан олох үр ашиг, өгөөжид дүн шинжилгээ, судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгийн зах зээлийн чиг хандлага, эрэлт, нийлүүлэлт, хөрөнгө оруулагчдын сонирхол, хуулийн этгээдийн үнэ цэн, үнэлгээг бодитой тогтоож шийдвэрлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурлаас 2001 онд “Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл”, 2005 онд “Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл, 2010 онд “Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл, 2013 онд “Төрийн өмчийг 2013-2014 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, 2015 онд “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, 2022 онд “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийг тус тус баталсан бөгөөд тэдгээрт тусгагдсан хэдий ч хэрэгжээгүй хувьчлал дийлэнх хувийг эзэлж байгаагаас гадна хүчингүйд тооцсон хувьчлалын асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Тодруулбал, дээрх шийдвэрүүдийн хэрэгжилт дараах байдалтай байна:

Он	Улсын Их Хурлын тогтоол	Үндсэн чиглэлд туссан төрийн өмчит хуулийн этгээдийн тоо	Хувьчлагдсан тоо	Хэрэгжилтийн хувь
2001 он	2001 оны 10 дугаар тогтоол	23	7	30%
2005 он	2005 оны 48 дугаар тогтоол	38	17	45%
2010 он	2010 оны 11 дүгээр тогтоол	9	1	11%
2015 он	2015 оны 70 дугаар тогтоол	19	2	11%
2022 он	2022 оны 16 дугаар тогтоол	26	2	8%
	Нийт (давхардсан тоогоор)	115	38	33%

Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн 4.17-д “Хөтлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах” гэж, Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоолоор баталсан “2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт”-ын 15-д “Хөтлийн цемент шохой” ТӨХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах гэж тус тус заасны дагуу хувьчилсан.

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолоор “Хөтлийн цемент шохой” компанийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах гэж заасан бөгөөд уг

шийдвэрийг үндэслэн Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоолоор тус компанийг хувьчилсан.

Авлигатай тэмцэх газар 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр “Мөрдөгчийн мэдэгдэл”-ийг ирүүлж, мэдэгдэлд “Хөтлийн Цемент Шохой” компанийг хувьчлахдаа “Бейзмент” ХХК-д давуу байдал бий болгон төрд их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдэгдсэн болохыг дурдаж, арга хэмжээ авахыг даалгасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасныг үндэслэн Засгийн газрын 2022 оны 124 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 108 дугаар тогтоолоор тус тус уг хувьчлалыг хүчингүйд тооцож, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлж, “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтын 4.17 дахь заалт буюу “Хөтлийн цемент шохой” компанийн хувьцааг хувьчлах заалтыг хүчингүй болгуулахаар 2022 онд Улсын Их Хуралд хүргүүлсэн асуудал шийдвэрлэгдээгүй байна.

Улсын Их Хурлын 2022 оны “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг батлах тухай” 244 дүгээр тогтоолыг холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу авч хэрэгжүүлэх явцад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2. хувьцааг биржээр арилжих үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмын дагуу явуулна. “...56.5.Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт энэ хуульд заасны дагуу нээлттэй хувьцаат компани болсон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно...” гэсэн өөрчлөлтийг нийт төрийн өмчит хуулийн этгээдүүдэд хамруулан 2022 онд хуульд оруулсан нь төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгээд байна.

Иймд хувьчлалыг үр дүнтэй зохион байгуулах үүднээс Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2. хувьцааг биржээр арилжих үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмын дагуу явуулна, аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт энэ хуульд заасны дагуу нээлттэй хувьцаат компани болсон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно гэсэн заалтыг өөрчлөх, эхний ээлжид дараах 18 компанийн нэмэлт хувьцааг гаргаж, хөрөнгө оруулалт татах, нээлттэй хувьцаат компани болгох зорилгоор хувьцааг нь биржээр арилжих, өөрчлөн байгуулах асуудлыг судалж, хувьчлалын арга хэлбэр, баримтлах зарчмыг тогтоох үндсэн чиглэлийг шийдвэрлүүлэх нь зүйтэй байна. Үүнд:

Нэмэлт хувьцаа гаргаж хөрөнгө оруулалт татах, нээлттэй хувьцаат компани болгох, хувьцааг нь биржээр нээлттэй арилжих:

1. “Монголын цахилгаан холбоо” ХК;
2. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК;
3. “Үндэсний давхар даатгал” ХК;
4. “Монголын хөрөнгийн бирж” ХК;
5. “Хөдөө аж ахуйн корпораци” ХХК;
6. “МИАТ” ТӨХК;
7. “Төрийн банк” ХК.
8. “Эрдэнэс Тавантолгой” ХК;

9. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ;
10. “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ
11. “Дулааны III цахилгаан станц” ХК;
12. “Дулааны IV цахилгаан станц” ХК;
13. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ХК;
14. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК;
15. “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК;
16. “Амгалан дулааны станц” ТӨХК;
17. “Шивээ овоо” ХК;
18. “Багануур” ХК

Төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, биржээр арилжих:

1. “Дулаан шарын гол” ТӨХК;
2. “Цемент шохой” ТӨХХК
3. “Монгол шуудан” ХК
4. “Багануур дулааны станц” ТӨХК;
5. “Налайхын дулаан станц” ТӨХК;
6. “Хөвсгөл дулааны станц” ТӨХК;
7. “Ховд дулааны станц” ТӨХК;
8. “Улаангомын дулааны II станц” ТӨХК;

Төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах, нэгтгэх, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх:

1. “Эрдэнэс Монгол” ХХК;
2. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК
3. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК;
4. “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ
5. “Автоимпекс” ХК
6. “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор” ХХК;
7. “Автозам засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК;

Ингэхдээ төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах бөгөөд төрийн өмчит компаниудын төрийн эзэмшлийн болон нэмж гаргах, стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох хувьцааны хувь хэмжээ, өөрчлөн зохион байгуулах хэлбэрийг үндсэн чиглэлээр тогтоох нь зүйтэй байна.

Түүнчлэн, өмнө нь батлагдсан үндсэн чиглэлүүдийн хэрэгжилтэд нэгдсэн үнэлгээ, дүгнэлт хийж, цаашид хэрхэх асуудлыг шийдвэрлэх болон төрийн нийтийн өмчид зайлшгүй байх хувьчилж үл болох хөрөнгө, ашгийн бус, нийгмийн шинжтэй төрөөс үйл ажиллагааг заавал хариуцан явуулах шаардлагатай төрийн өмчит хуулийн этгээдийн төрөл, чиглэлийг тодорхойлж, тэдгээрээс бусад төрийн өмчийн компаниудыг үе шаттайгаар өөрчлөн байгуулах, нээлттэй хувьцаат компани болгох, хувьцааг нь биржээр олон нийтэд нээлттэй худалдах замаар бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог бууруулах, олон нийтийн хяналтад оруулах, стратегийн хөрөнгө оруулалт татах, хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах арга хэмжээг судалгаа, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Мөн төрөөс аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж, бүтэц, орон тоо бий болгодог, их хэмжээний үргүй зардал гаргадаг байдлыг халах зорилгоор алдагдалтай, цаашид ашигтай ажиллах боломжгүй болсон, хувийн хэвшил хэрэгжүүлэх боломжтой төрийн өмчит хуулийн этгээдүүдийг татан буулгах, илүүдэлтэй хөрөнгийг худалдах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь 3 заалттай байх бөгөөд “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл”-ийг батлах болон өмнө нь батлагдсан үндсэн чиглэлүүдийн хэрэгжилтэд нэгдсэн үнэлгээ, дүгнэлт хийж, хувьчлалыг амжилттай явуулах чиглэлээр бодит тооцоо, судалгаанд тулгуурласан холбогдох арга хэмжээ авч, шаардлагатай бол тодорхой санал боловсруулан шийдвэрлүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгах болон тогтоол гарсантай холбогдуулан хүчингүй болгох зохицуулалтыг тус тус тусгана.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Тогтоолын төсөл батлагдсанаар төрийн өмчит компаниуд олон нийтийн хяналтад орох, улс орны эдийн засагт олон нийтийн болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр компанийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, орлого олох үндсэн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах төсөл арга хэмжээнд зарцуулах, компанийн засаглал сайжирч, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, төр болон хувийн хэвшлийн түншлэлийн зохистой хэлбэрийг бий болгоно.

Дөрөв. Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуультай тус тус нийцнэ.

-----oOo-----

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

"Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Өмч хувьчлал нь нэг тогтолцооноос нөгөө тогтолцоонд шилжихтэй холбоотой нийгэм, эдийн засгийн бусад томоохон арга хэмжээтэй зэрэгцэн хэрэгжиж, хувийн хэвшлийг хөгжүүлэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах, бага зардлаар чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болох, өмчийн олон талт харилцаа хөгжих, эдийн засагт хувийн хэвшлийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийг нэмэгдүүлэх түүхэн үүргээ 35 жил гүйцэтгэж ирсэн үйл явцыг судалсны үндсэн дээр Монгол Улс дахь өмч хувьчлалын үйл явцыг үндсэн таван үе шат болгон авч үзлээ. Үүнд:

- Өмч хувьчлалын I үе буюу 1991-1995 он
- Өмч хувьчлалын II үе буюу 1996-2000 он
- Өмч хувьчлалын III үе буюу 2001-2004 он
- Өмч хувьчлалын IV үе буюу 2005-2016 он
- Өмч хувьчлалын V үе буюу 2017-2025 он

1991-1995 онд нийт 919 аж ахуйн нэгжийн 12.6 тэрбум төгрөгийн хөрөнгө, 1996-2000 онд битүүмжилсэн дуудлага худалдаагаар 6.6 тэрбум төгрөгөөр нийт 75 аж ахуйн нэгж, нийтийн дуудлага худалдаагаар 40.8 тэрбум төгрөгөөр 847 аж ахуйн нэгжийг хувьчилсан байна. 2001-2004 онд 83 аж ахуйн нэгжийн 62.6 тэрбум төгрөг, 2005-2016 онд 89 аж ахуйн нэгжийн 102.4 тэрбум, 2017 онд нийт 4 аж ахуйн нэгжийн 16.2 тэрбум төгрөг, 2022 онд Төрийн банкны 5.71 хувийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд нээлттэй арилжихад 7306 хувь хүн, аж ахуйн нэгжээс 67.3 тэрбум төгрөгийн санал ирүүлж, 25.4 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн, Монголын хөрөнгийн биржийн 34 хувийн хувьцааг 7414 хувь хүн, аж ахуйн нэгжээс 57.8 тэрбум төгрөгийн санал ирүүлж, 11.9 тэрбум төгрөгөөр тус тус арилжсан. 1991 оноос хойш 278.5 тэрбум төгрөгийн дүн бүхий 2,019 аж ахуйн нэгж, үл хөдлөх хөрөнгө, хувьцааг бүхэлд нь эсвэл тодорхой хувийг нээлттэй дуудлага худалдаа, хөрөнгийн биржээр дамжуулах болон бусад холбогдох арга хэлбэрээр худалдан, хувьчилсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална" гэж, Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ" гэж тус тус хуульчилсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад "Улсын Их Хурал төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл, хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг батлах, түүнд өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй" гэж заасан.

Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжина” гэж заасан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтад Засгийн газар “чиг үүргийн давхардалтай, эсхүл чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх зэргээр удирдлагын зардлыг хэмнэх” арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны Ухаалаг засаглалын зорилгын 5.2.19-д “Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дугаар тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023–2030 он/-ийн **Зорилт 8.3-т** “Төрийн болон орон нутгийн өмчит компани, түүний охин компанийг үүсгэн байгуулах, татан буулгах, бүтцийн өөрчлөлт хийхэд мөнгөн урсгал, техник, эдийн засгийн үндэслэл, улсын төсөвт төвлөрүүлэх татвар болон судалгаа, дүн шинжилгээнд тулгуурладаг байна. Алдагдалтай ажилласан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын шалгалт хийж, үндэслэл, шалтгааныг тогтоож, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2.4-т “төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ” гэж, 3.3.3.1-д Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлах, эрчим хүчний салбарыг чөлөөт зах зээлийн зарчимд шилжүүлж, үнэ тарифыг зохистой түвшинд хүргэн, цаашид тогтмол индексжүүлэх тогтолцоог нэвтрүүлж, салбарын эрх зүйн орчныг шинэчилнэ” гэж, 4.1.4.2-т “төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагааг явуулах тогтолцоог бүрдүүлэх...” гэж, 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэсэн зорилтыг тус тус дэвшүүлсэн.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 52 дугаар тогтоолын 2 дахь заалтын 3 дахь дэд заалтад төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах асуудлын талаар холбогдох санал боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

“Шинэ итгэл-Эрс шинэтгэл” “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд төрийн өмчит компанийн засаглалыг олон улсын компанийн засаглалын зарчимд нийцүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх, Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны бүртгэл,

мэдээллийн ил тод байдлыг бүрэн ханган төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалтын цахим шилжилтийг хийх зорилтыг тусгасан.

Нөхцөл байдал, практик

“Төрийн банк” хувьцаат компани

Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 56 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 34 дүгээр тэмдэглэл, Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн хамтарсан 2022 оны 30/A191 дүгээр тушаалаар баталсан “Төрийн банк”-ийг олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд “Төрийн банк” хувьцаат компанийн 712,000,000 (долоон зуун арван хоёр сая) ширхэг энгийн хувьцаа дээр 37,475,000 (гучин долоо сая дөрвөн зуун далан таван мянган) ширхэг энгийн хувьцааг нэмж гаргаж, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгох Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол гаргасан. Үүнд:

а. Олон нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг 590 (таван зуун ерэн) төгрөгөөр тогтоосон.

б. “Төрийн банк” хувьцаат компанийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжих үйл ажиллагааг Үнэт цаасны тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулахыг “Төрийн банк” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захиралд тус тус зөвшөөрсөн.

в. “Төрийн банк” хувьцаат компанийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжих үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус банкны Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчдэд зөвлөсөн.

“Төрийн банк” ХК-ийн нийт хувьцааны 5% буюу 34,745,000 ширхэг хувьцааг нэгж хувьцааны үнэ 590 төгрөгөөр тооцон 22.1 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр тооцсон. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болж, 5.71 хувийн хувьцааг 7306 хувь хүн, аж ахуйн нэгж санал ирүүлж, 25.4 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн болно.

“Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компани

Улсын Их Хурлын 2022 оны “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” 16 дугаар тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 66 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган биржээр арилжиж, түүнээс олох орлогыг компанийн техник, технологийн шинэчлэлд ашиглахаар заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 244 дүгээр тогтоолоор “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт”-ыг баталж, төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг биржээр худалдахтай холбогдсон арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу авч хэрэгжүүлэх, шаардагдах эх үүсвэрийг тооцох, төрийн өмчит хуулийн этгээдийг олон нийтийн шууд хяналтад оруулах бодлогын хүрээнд хуулийн этгээдийн энгийн хувьцааг нэмж гаргах, хувьцаа гаргах бэлтгэл хангах, биржээр олон нийтэд нээлттэй худалдах, нээлттэй хувьцаат компани болгож, өөрчлөн байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдах ажлыг эрчимжүүлэх, мөн зах зээл дэх төрийн оролцоог

багасгах, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэх хүрээнд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт хувьцааны 34% буюу 119,157,603 ширхэг хувьцааг нэгж хувьцааны үнэ 100 төгрөгөөр тооцон 11.9 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр нийтэд санал болгосон. Анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 7,085 хөрөнгө оруулагчаас 577,657,455 ширхэг буюу 57,765,745,500 /тавин долоон тэрбум долоон зуун жаран таван сая долоон зуун дөчин таван мянга таван зуу/ төгрөгийн үнийн дүн бүхий 7,413 захиалга ирүүлсэн бөгөөд үнэт цаасны танилцуулга болон андеррайтерийн компаниас ирүүлсэн хуваарилалтын төлөвлөгөөний дагуу 500 ширхэг хүртэлх хувьцааны захиалгыг 100 хувь биелүүлж, үлдсэн үнийн дүнг 11.8 хувиар хувь тэнцүүлэн хуваарилалт хийж нийт 11.9 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Улсын Их Хурлын 2022 оны “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг батлах тухай” 244 дүгээр тогтоолыг холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу авч хэрэгжүүлэх явцад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2. хувьцааг биржээр арилжих үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмын дагуу явуулна. “...56.5.Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт энэ хуульд заасны дагуу нээлттэй хувьцаат компани болсон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно...” гэсэн өөрчлөлтийг нийт төрийн өмчит хуулийн этгээдүүдэд хамруулан 2022 онд хуульд оруулсан нь төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгээд байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах хүрээнд төрийн өмчит компанийн үр ашгийг нэмэгдүүлэх, олон нийтийн хяналтад оруулж, санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангуулах болон төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог бууруулах зорилгоор хувьчлалыг үр дүнтэй зохион байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийг нээлттэй хувьцаат компани болгох, хувьцааг нь биржээр олон нийтэд нээлттэй худалдах, өөрчлөн зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг тогтоох шаардлагатай байна.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу төрийн нийтийн өмч, түүний төрөл, зүйлийг тодорхойлох, өмчийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийг шинэчлэх, өөрчлөлт оруулах замаар хэрэгжүүлэх бөгөөд үүнтэй уялдуулан төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл тогтоох асуудлыг өнөөгийн нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлага, бизнесийн орчин нөхцөл болон олон улсын сайн туршлага, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) зэрэг холбогдох бусад байгууллагын судалгаа, зөвлөмжид тулгуурлан олох үр ашиг, өгөөжид дүн шинжилгээ, судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгийн зах зээлийн чиг хандлага, эрэлт, нийлүүлэлт, хөрөнгө оруулагчдын сонирхол, хуулийн этгээдийн үнэ цэн, үнэлгээг бодитой тогтоож шийдвэрлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурлаас 2001 онд “Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл”, 2005 онд “Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, 2010 онд “Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, 2013 онд “Төрийн өмчийг 2013-2014 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, 2015 онд “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, 2022 онд “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийг тус тус баталсан бөгөөд тэдгээрт тусгагдсан хэдий ч хэрэгжээгүй хувьчлал дийлэнх хувийг эзэлж байгаагаас гадна хүчингүйд тооцсон хувьчлалын асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Хувьчлалыг үр дүнтэй зохион байгуулах үүднээс эхний ээлжид дараах 33 компанийн нэмэлт хувьцааг гаргаж хөрөнгө оруулалт татах, нээлттэй хувьцаат компани болгох зорилгоор хувьцааг нь биржээр арилжих, өөрчлөн байгуулах асуудлыг судалж, хувьчлалын арга хэлбэр, баримтлах зарчмыг тогтоох үндсэн чиглэлийг шийдвэрлүүлэх нь зүйтэй байна. Үүнд:

Нэмэлт хувьцаа гаргаж хөрөнгө оруулалт татах, нээлттэй хувьцаат компани болгох, хувьцааг нь биржээр нээлттэй арилжих:

1. “Монголын цахилгаан холбоо” ХК;
2. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК;
3. “Үндэсний давхар даатгал” ХК;
4. “Монголын хөрөнгийн бирж” ХК;
5. “Хөдөө аж ахуйн корпораци” ХХК;
6. “МИАТ” ТӨХК;
7. “Төрийн банк” ХК.
8. “Эрдэнэс Тавантолгой” ХК;
9. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ;
10. “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ
11. “Дулааны III цахилгаан станц” ХК;
12. “Дулааны IV цахилгаан станц” ХК;
13. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ХК;
14. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК;
15. “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК;
16. “Амгалан дулааны станц” ТӨХК;
17. “Шивээ овоо” ХК;
18. “Багануур” ХК

Төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, биржээр арилжих:

1. “Дулаан шарын гол” ТӨХК;
2. “Цемент шохой” ТӨХК
3. “Монгол шуудан” ХК
4. “Багануур дулааны станц” ТӨХК;
5. “Налайхын дулаан станц” ТӨХК;
6. “Хөвсгөл дулааны станц” ТӨХК;
7. “Ховд дулааны станц” ТӨХК;
8. “Улаангомын дулааны II станц” ТӨХК;

Төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах, нэгтгэх, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх:

1. “Эрдэнэс монгол” ХХК;
2. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК
3. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК;
4. “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ
5. “Автоимпекс” ХК

6. “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор” ХХК;
7. “Автозам засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК;

Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах бөгөөд төрийн өмчит компаниудын төрийн эзэмшлийн болон нэмж гаргах, стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох хувьцааны хувь хэмжээ, өөрчлөн зохион байгуулах хэлбэрийг үндсэн чиглэлээр тогтоох нь зүйтэй байна.

Түүнчлэн, өмнө нь батлагдсан үндсэн чиглэлүүдийн хэрэгжилтэд нэгдсэн үнэлгээ, дүгнэлт хийж, цаашид хэрхэх асуудлыг шийдвэрлэх болон төрийн нийтийн өмчид зайлшгүй байх хувьчилж үл болох хөрөнгө, ашгийн бус, нийгмийн шинжтэй төрөөс үйл ажиллагааг заавал хариуцан явуулах шаардлагатай төрийн өмчит хуулийн этгээдийн төрөл, чиглэлийг тодорхойлж, тэдгээрээс бусад төрийн өмчийн компаниудыг үе шаттайгаар өөрчлөн байгуулах, нээлттэй хувьцаат компани болгох, хувьцааг нь биржээр олон нийтэд нээлттэй худалдах замаар бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог бууруулах, олон нийтийн хяналтад оруулах, стратегийн хөрөнгө оруулалт татах, хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах арга хэмжээг судалгаа, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Иймд өнгөрсөн 35 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн өмч хувьчлалын алдаа, оноонд дүгнэлт хийж, Улсын Их Хурлаас баталсан хувьчлах үндсэн чиглэлүүдийн хэрэгжилтэд нэгдсэн үнэлгээ, дүгнэлт хийж, хувьчлалыг амжилттай явуулах чиглэлээр бодит тооцоо, судалгаанд тулгуурласан холбогдох арга хэмжээ авч, шаардлагатай бол тодорхой санал боловсруулан шийдвэрлүүлж ажиллах, Үндсэн хуулийн агуулгад нийцүүлэн төрийн нийтийн өмч, түүний төрөл, зүйлийг тодорхойлж, бусдад шилжүүлэх болон өмчийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлэх харилцааг өнөөгийн нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлага, олон улсын туршлагын дагуу тогтоох асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэн найруулж, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах замаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2025 оны байдлаар уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц, зам, тээвэр, банк, санхүү, мэдээлэл харилцаа зэрэг салбаруудад толгой компани 84, тэдгээрийн охин, хараат компани 17 нийт 101 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрууд үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээр компани, үйлдвэрийн газруудаас 100% төрийн өмчийн 73, төрийн өмчийн оролцоотой 22, олон нийтийн нээлттэй хувьцаат компани 6 байна.

Хариуцлагын хэлбэрээр нь задалбал төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ) – 15, төрийн өмчит хувьцаат компани (ТӨХК) – 28, төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани (ТӨХХК) – 30, төрийн өмчийн оролцоотой хаалттай хувьцаат компани (ХК) – 2, төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) – 19, төрийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн нийгэмлэг (ХНН) – 1, төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компани (ХК) – 2 байна.

Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр нь авч үзвэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (түүний харьяанд “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрчист Монгол” ХХК болон тэдгээрийн харьяа компаниудыг оролцуулаад нийт 41 ТӨК), Эрчим хүчний яам (түүний харьяанд 28 ТӨК), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (түүний харьяанд 14 ТӨК), Сангийн яам (түүний харьяанд 5 ТӨК), Зам, тээврийн яам (түүний харьяанд 5 ТӨК), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (түүний харьяанд 4 ТӨК), Эдийн засаг, хөгжлийн яам (түүний харьяанд 2 ТӨК), Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (түүний харьяанд 1 ТӨК), Хууль зүй, дотоод хэргийн яам (түүний харьяанд 1 ТӨК) зэрэг нийт 11 хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нар байна.

Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрууд нь 2024 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн нэгтгэсэн дүнгээр нийт хөрөнгө 59.4 их наяд төгрөг буюу ДНБ-ний 74.3% ("Эрдэнэс тавантолгой" ХК, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ийн дүнг хасвал ДНБ-ний 35.9%), нийт орлого 26.0 их наяд төгрөг буюу ДНБ-ний 32.5% ("Эрдэнэс тавантолгой" ХК, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ийн дүнг хасвал ДНБ-ний 18.5%), нийт өр төлбөр 22.9 их наяд төгрөг буюу ДНБ-ний 28.6% ("Эрдэнэс тавантолгой" ХК, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ийн дүнг хасвал ДНБ-ний 18.7%)-тай тус тус тэнцэж байна. Нийт хөрөнгийн 63% буюу 37.4 их наяд төгрөг, нийт орлогын 63% буюу 16.4 их наяд төгрөг, нийт өр төлбөрийн 29% буюу 6.6 их наяд төгрөгийг уул уурхайн салбарын төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын дүн эзэлж байна.

Сүүлийн 5 жилд буюу 2021-2025 онуудад төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын чиг үүргийн давхардлыг арилгах, үр ашгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах арга хэмжээг авч 135 байсан төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын тоог 101 болгон 34-өөр буюу 25.2%-иар бууруулаад байна.

Мөн төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын хөрөнгийн өгөөж 2021 онд 1.94% байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 9.63% болж нэмэгдсэн, 2021 онд 1 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 5.7 их наяд төгрөг болж өссөн үзүүлэлттэй байна. Гэвч нийт орлогын 56%, цэвэр ашгийн 89%-ийг уул уурхайн салбарын "Эрдэнэс тавантолгой" ХК болон "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ийн дүн эзэлж байгаа тул цаашид төрийн өмчит компанийн шинэчлэлийн бодлогыг үргэлжүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Цаашид төрийн өмчит компаниудад баримтлах бодлого, чиглэлийг тодорхой болгох үүднээс төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудыг тодорхой шалгуурын хүрээнд ангилж авч үзэх, тэдгээрийн ангилалын хүрээнд төрийн зүгээс тухайн компанид оролцох өмчлөлийн бодлогыг ангилал тус бүрийн онцлогт тулгуурлан ялгамжтай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төрийн өмчит компаниудыг дараах 3 ангилалд авч үзэхээр байна. Үүнд:

Нэг. Бизнесийн болон өрсөлдөөнд суурилсан төрийн өмчит компани

Хувийн хэвшилтэй зэрэгцэн үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудын хувьцааг бүхэлд нь худалдах эсвэл төрийн өмчийн оролцоог 34%-иас ихгүй байлгах.

Хоёр. Стратегид суурилсан төрийн өмчит компани

Стратегийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа, төрөөс тодорхой зохицуулалт шаардлагатай төрийн өмчит компаниудыг олон нийтийн шууд хяналтад оруулах замаар дотоод гадаадын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд хувьцааг нь санал болгон худалдаж, олон нийтийн нээлттэй хувьцаат компани болгох, төрийн мэдлийн хувьцааг 51%-иас доошгүй байлгах.

Гурав. Нийгмийн үйлчилгээ, дэд бүтэц, тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн өмчит компани

Тодорхой хууль тогтоомжийн хүрээнд төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг, нийгэм, иргэд рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг, нийгмийн үр ашгийг чухалчилдаг төрийн өмчит компани болон үйлдвэрийн газруудтай байх шаардлага зайлшгүй тулгардаг.

Төрийн зүгээс 100% хувьцааг нь эзэмшиж, төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын ил тод, нээлттэй байдлыг бий болгох, төрөөс тэдгээр байгууллагад олгож буй аливаа санхүүжилтыг ил тод тайлагнадаг байх, засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, бүтээмж, үр ашгийг хамгийн боломжит өндөр түвшинд байлгах нь зүйтэй байна.

Мөн чиг үүргийн давхардлыг арилгах, бүтэц орон тоог оновчлох замаар төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудыг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд татан буулгах арга хэмжээг үргэлжүүлэн авч ажиллах саналтай байна.

Дээрх ажлын хүрээнд “Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийн төсөлд 18 төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын төрийн мэдлийн 10-66 хүртэлх хувийн хувьцааг олон нийтэд хөрөнгийн биржээр дамжуулан санал болгон худалдаж нээлттэй хувьцаат компани болгох, 8 төрийн өмчит компанийн хувьцааг бүхэлд нь худалдах, 7 төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудыг нэгтгэх, нийлүүлэх, бүтцийн өөрчлөлт хийх, саналыг тусгаад байна.

Цаашид төрийн өмчит хуудийн этгээдийг биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын тоо нийт дүнгээр 101 байсныг 19-ээр буюу 18.8%-иар бууруулж 82 болгохоор төлөвлөж байна.

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл”-ийн төслийг боловсруулж, Эрчим хүчний яам, Сангийн яам, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Зам тээврийн яам, Монополын эсрэг газар, “Эрдэнэс монгол” ХХК, “Эрчист монгол” ХХК болон Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Нээлттэй форум нийгэмлэгээс санал авч нэгтгэсэн.

Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын <https://pcsp.gov.mn/?p=7964> сайтаар иргэд олон нийтээс Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэлийн төсөлд санал авах ажлыг зохион байгуулсан ба 24 иргэнээс төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн төсөлд дэмжсэн санал ирүүлсэн болно.

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл”-ийн төслийг боловсруулж, Эрчим хүчний яам, Сангийн яам, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Зам тээврийн яам, Монополын эсрэг газар, “Эрдэнэс монгол” ХХК, “Эрчист монгол” ХХК болон Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Нээлттэй форум нийгэмлэгээс санал авч нэгтгэсэн.

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган, “Шинэ итгэл-Эрс шинэтгэл” “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн дахин боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрчим хүчний яам, Сангийн яам, Цахим хөгжил, инновац,

харилцаа холбооны яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Батлан хамгаалах яам, Гэр бүл, нийгмийн хамгааллын яам, Монгол Улсын Шадар сайд, Гадаад харилцааны яам, Боловсролын яамны саналыг авч нэгтгэж, холбогдох өөрчлөлтүүдийг оруулсан болно.

Улсын Их Хурлын 2001 онд баталсан “Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл”, 2005 онд баталсан “Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл, 2010 онд баталсан “Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл, 2013 онд баталсан “Төрийн өмчийг 2013-2014 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, 2015 онд баталсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтэд нэгдсэн үнэлгээ, дүгнэлт хийж, хувьчлалыг амжилттай явуулах чиглэлээр бодит тооцоо, судалгаанд тулгуурласан холбогдох арга хэмжээ авч, шаардлагатай бол тодорхой санал боловсруулан, үе шаттайгаар шийдвэрлүүлж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад "Улсын Их Хурал төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл, хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг батлах, түүнд өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй" гэж заасан.

Монгол Улсын Их Хурлаас 2001 онд "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл", 2005 онд "Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл", 2010 онд "Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл", 2013 онд "Төрийн өмчийг 2013-2014 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл", 2015 онд "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл", 2022 онд "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-ийг тус тус баталсан бөгөөд тэдгээрт тусгагдсан хэдий ч хэрэгжээгүй хувьчлал дийлэнх хувийг эзэлж байгаагаас гадна хүчингүйд тооцсон хувьчлалын асуудлыг шийдвэрлүүлэх шаардлага үүсээд байна.

2025 оны байдлаар уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц, зам, тээвэр, банк, санхүү, мэдээлэл харилцаа зэрэг салбаруудад толгой компани 84, тэдгээрийн охин, хараат компани 17 нийт 101 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрууд үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээр компани, үйлдвэрийн газруудаас 100% төрийн өмчийн 73, төрийн өмчийн оролцоотой 22, олон нийтийн нээлттэй хувьцаат компани 6 байна.

Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрууд нь 2024 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн нэгтгэсэн дүнгээр нийт хөрөнгө 59.4 их наяд төгрөг буюу ДНБ-ний 74.3% ("Эрдэнэс тавантолгой" ХК, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ийн дүнг хасвал ДНБ-ний 35.9%), нийт орлого 26.0 их наяд төгрөг буюу ДНБ-ний 32.5% ("Эрдэнэс тавантолгой" ХК, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ийн дүнг хасвал ДНБ-ний 18.5%), нийт өр төлбөр 22.9 их наяд төгрөг буюу ДНБ-ний 28.6% ("Эрдэнэс тавантолгой" ХК, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ийн дүнг хасвал ДНБ-ний 18.7%)-тай тус тус тэнцэж байна. Нийт хөрөнгийн 63% буюу 37.4 их наяд төгрөг, нийт орлогын 63% буюу 16.4 их наяд төгрөг, нийт өр төлбөрийн 29% буюу 6.6 их наяд төгрөгийг уул уурхайн салбарын төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын дүн эзэлж байна.

Сүүлийн 5 жилд буюу 2021-2025 онуудад төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын чиг үүргийн давхардлыг арилгах, үр ашгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах арга хэмжээг авч 135 байсан төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын тоог 101 болгон 34-өөр буюу 25.2%-иар бууруулаад байна.

Мөн төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын хөрөнгийн өгөөж 2021 онд 1.94% байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 9.63% болж нэмэгдсэн, 2021 онд 1 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 5.7 их наяд төгрөг болж өссөн үзүүлэлттэй байна. Гэвч нийт орлогын 56%,

цэвэр ашгийн 89%-ийг уул уурхайн салбарын “Эрдэнэс тавантолгой” ХК болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн дүн эзэлж байгаа тул цаашид төрийн өмчит компанийн шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Цаашид төрийн өмчит компаниудад баримтлах бодлого, чиглэлийг тодорхой болгох үүднээс төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудыг тодорхой шалгуурын хүрээнд ангилж авч үзэх, тэдгээрийн ангиллын хүрээнд төрийн зүгээс тухайн компанид оролцох өмчлөлийн бодлогыг ангилал тус бүрийн онцлогт тулгуурлан ялгамжтай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үүнд:Төрийн өмчит компаниудыг дараах 3 ангилалд авч үзэх:

Нэг. Бизнесийн болон өрсөлдөөнд суурилсан төрийн өмчит компани

Хувийн хэвшилтэй зэрэгцэн үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудын хувьцааг бүхэлд нь худалдах эсвэл төрийн өмчийн оролцоог 34%-аас ихгүй байлгах.

Хоёр. Стратегид суурилсан төрийн өмчит компани

Стратегийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа, төрөөс тодорхой зохицуулалт шаардлагатай төрийн өмчит компаниудыг олон нийтийн шууд хяналтад оруулах замаар дотоод гадаадын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд хувьцааг нь санал болгон худалдаж, олон нийтийн нээлттэй хувьцаат компани болгох, төрийн мэдлийн хувьцааг 51%-аас доошгүй байлгах.

Гурав. Нийгмийн үйлчилгээ, дэд бүтэц, тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн өмчит компани

Тодорхой хууль тогтоомжийн хүрээнд төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг, нийгэм, иргэд рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг, нийгмийн үр ашгийг чухалчилдаг төрийн өмчит компани болон үйлдвэрийн газруудтай байх шаардлага зайлшгүй тулгардаг. Төрийн зүгээс 100% хувьцааг нь эзэмшиж, төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын ил тод, нээлттэй байдлыг бий болгох, төрөөс тэдгээр байгууллагад олгож буй аливаа санхүүжилтийг ил тод тайлагнадаг байх, засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, бүтээмж, үр ашгийг хамгийн боломжит өндөр түвшинд байлгах нь зүйтэй байна.

Мөн чиг үүргийн давхардлыг арилгах, бүтэц орон тоог оновчлох замаар төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудыг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд татан буулгах арга хэмжээг үргэлжлүүлэн авч ажиллах саналтай байна.

Дээрх ажлын хүрээнд “Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийн төсөлд 18 төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын төрийн мэдлийн 10-66 хүртэлх хувийн хувьцааг олон нийтэд хөрөнгийн биржээр дамжуулан санал болгон худалдаж нээлттэй хувьцаат компани болгох, 8 төрийн өмчит компанийн хувьцааг бүхэлд нь худалдах, 7 төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудыг нэгтгэх, нийлүүлэх, бүтцийн өөрчлөлт хийх саналыг тусгаад байна.

Цаашид төрийн өмчит хуулийн этгээдийг биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах арга хэмжээг үргэлжлүүлэн

хэрэгжүүлснээр төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын тоо нийт дүнгээр 101 байсныг 19-ээр буюу 18.8%-аар бууруулж 82 болгохоор төлөвлөж байна.

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд төрийн өмчит компаниуд олон нийтийн хяналтад орох, улс орны эдийн засагт олон нийтийн болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр компанийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, орлого олох үндсэн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах төсөл арга хэмжээнд зарцуулах, компанийн засаглал сайжирч, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, төр болон хувийн хэвшлийн түншлэлийн зохистой хэлбэрийг бий болгох хүрээнд “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл”-ийг батлах саналыг тусгасан.

Мөн өмнө нь батлагдсан үндсэн чиглэлүүдийн хэрэгжилтийн хувь хангалтгүй 37 хувьтай байгаад үнэлэлт, дүгнэлт хийж, цаашид хэрхэх асуудлыг шийдвэрлэх болон төрийн нийтийн өмчид зайлшгүй байх хувьчилж үл болох хөрөнгө, ашгийн бус, нийгмийн шинжтэй төрөөс үйл ажиллагааг заавал хариуцан явуулах шаардлагатай төрийн өмчит хуулийн этгээдийн төрөл, чиглэлийг тодорхойлж, тэдгээрээс бусад төрийн өмчийн компаниудыг үе шаттайгаар өөрчлөн байгуулах, нээлттэй хувьцаат компани болгох, хувьцааг нь биржээр олон нийтэд нээлттэй худалдах замаар бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог бууруулах, олон нийтийн хяналтад оруулах, стратегийн хөрөнгө оруулалт татах, хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх тодорхой санал боловсруулан шийдвэрлүүлэх байдлаар тусгасан болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад хувьцааг биржээр арилжих үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмын дагуу явуулна” гэж, мөн зүйлийн 5 дахь заалтад “Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт энэ хуульд заасны дагуу нээлттэй хувьцаат компани болсон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно” гэж заасан нь төрийн өмчит нийт хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсгээд байгааг өөрчлөх чиглэлээр санал боловсруулж, шийдвэрлүүлэх асуудлыг үндсэн чиглэлийн төсөлд мөн тусгасан болно.

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл”-ийн төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрчим хүчний яам, Сангийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Батлан хамгаалах яам, Гэр бүл, нийгмийн хамгааллын яам, Монгол Улсын Шадар сайд, Гадаад харилцааны яам, Боловсролын яамны, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Зам тээврийн яам, Монополын эсрэг газар, “Эрдэнэс монгол” ХХК, “Эрчист монгол” ХХК болон Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Нээлттэй форум нийгэмлэгээс санал авч нэгтгэсэн ба Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын <https://pcsp.gov.mn/?p=7964> сайтаар иргэд олон нийтээс Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэлийн төсөлд санал авах ажлыг зохион байгуулсан.

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэлийг

Улсын Их Хурлын дахь Монгол Ардын намын бүлгийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжсэн болно.

-----oOo-----

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

"Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай"

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, "Шинэ итгэл-Эрс шинэтгэл" "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Улсын Их Хурлаас 2001-2022 онд баталсан төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах болон төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлүүдийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлж, Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай:

2.1. төрийн нийтийн өмчид зайлшгүй байх хувьчилж үл болох хөрөнгө болон ашгийн бус, нийгмийн шинжтэй төрөөс үйл ажиллагааг заавал хариуцан явуулах шаардлагатай төрийн өмчит хуулийн этгээдийн төрөл, чиглэлийг тодорхойлж, холбогдох жагсаалтыг боловсруулж, шийдвэрлүүлэх;

2.2. Улсын Их Хурлаас 2001-2022 онд баталсан төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах болон төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлүүдийн хэрэгжилтэд нийгэм, эдийн засаг, санхүүгийн өнөөгийн бодит нөхцөлд бодитой үнэлэлт, дүгнэлт хийж, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах талаар цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, шийдвэрлүүлэх.

3. "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-ийн 4.1, 4.2, 4.4, 4.5, 4.7, 4.14, 4.17 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

**ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХУВЬЦААГ 2026-2028 ОНД
БИРЖЭЭР ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХУДАЛДАХ, ТӨРИЙН ӨМЧИЙГ
ХУВЬЧЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ****НЭГ.ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗОРИЛГО**

1.1. Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн зорилго нь төрийн өмчийг хувьчлах үйл ажиллагааг үе шаттай, үр дүнтэй зохион байгуулах, төрийн өмчит компанийн хувьцааг олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгох, нэмж хувьцаа гаргах замаар олон нийтийн хяналтад оруулж, засаглалыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, санхүүгийн сахилга бат, ил тод байдлыг хангуулж Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг дэмжихэд оршино.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2.4-т “төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ” гэж, 3.3.3.1-д Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлах, эрчим хүчний салбарыг чөлөөт зах зээлийн зарчимд шилжүүлж, үнэ тарифыг зохистой түвшинд хүргэн, цаашид тогтмол индексжүүлэх тогтолцоог нэвтрүүлж, салбарын эрх зүйн орчныг шинэчилнэ” гэж, 4.1.4.2-т “төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагааг явуулах тогтолцоог бүрдүүлэх...” гэж, 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэсэн зорилтыг тус тус дэвшүүлсэн.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 52 дугаар тогтоолын 2 дахь заалтын 3 дахь дэд заалтад төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах асуудлын талаар холбогдох санал боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

“Шинэ итгэл-Эрс шинэтгэл” “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд төрийн өмчит компанийн засаглалыг олон улсын компанийн засаглалын зарчимд нийцүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх, Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны бүртгэл, мэдээллийн ил тод байдлыг бүрэн ханган төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалтын цахим шилжилтийг хийх зорилтыг тусгасан.

ХОЁР. ҮНДСЭН ЗАРЧИМ

2.1. Төрийн өмчийг хувьчлах, төрийн өмчит компанийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдахад дараах үндсэн зарчмыг баримтална:

2.1.1. Төрийн өмчит компанийн хувьцааг олон нийтэд нээлттэй санал болгох, нэмж хувьцаа гаргах замаар олон нийтийн нээлттэй хувьцаат компани болгох, нэмж хувьцаа гаргах замаар олон нийтийн хяналтад оруулж, засаглалыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, санхүүгийн сахилга бат, ил тод байдлыг хангуулах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит компанийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах арга хэмжээг хууль эрх зүйн хүрээнд ил тод, нээлттэй хэрэгжүүлэх;

2.1.2. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлэх;

2.1.3. Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлах, эрчим хүчний салбарыг чөлөөт зах зээлийн зарчимд шилжүүлж, үнэ тарифыг зохистой түвшинд хүргэн, цаашид тогтмол индексжүүлэх тогтолцоог нэвтрүүлж, салбарын эрх зүйн орчныг шинэчлэх;

2.1.4. Төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг бүрэн арилжих, худалдах;

2.1.5. Төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх;

2.2. Зах зээл дэх төрийн оролцоог багасгах, хувийн хэвшил бие даан гүйцэтгэх боломжтой салбар дахь төрийн аж ахуйн үйл ажиллагааг зогсоож, зах зээлийн өрсөлдөөний зарчмаар хөгжих боломжийг хангах;

2.3. Төрийн эзэмшлийн хувьцааг худалдсаны орлого болон төрийн мэдлийн энгийн хувьцааг худалдаж орсон орлогын тодорхой хувийг улсын төсөвт төвлөрүүлэх;

2.4. Тухайн салбарт бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тарифыг зах зээлийн зарчмаар тогтоох боломжийг нэмэгдүүлэх;

2.5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт нээлттэй хувьцаат компани болсон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглосон зохицуулалтыг бирж дээр хувьцааг нь арилжиж буй төрийн өмчит компанийн онцлогоос хамаарч өөр байхаар өөрчлөх чиглэлээр санал боловсруулж, шийдвэрлүүлэх.

ГУРАВ. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АРГА, ХЭЛБЭР

3.1. Үндсэн чиглэлийг дараах зохион байгуулалттайгаар хэрэгжүүлнэ:

3.1.1. Улсын Их Хурлаас 2001-2022 онд баталсан төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах болон төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлүүдийн хэрэгжилтэд нийгэм, эдийн засаг, санхүүгийн өнөөгийн бодит нөхцөлд бодитой үнэлэлт, дүгнэлт хийж, төрийн нийтийн өмчид зайлшгүй байх, хувьчилж үл болох хөрөнгө болон ашгийн бус, нийгмийн шинжтэй төрөөс үйл ажиллагааг заавал хариуцан явуулах шаардлагатай төрийн өмчит хуулийн этгээдийн төрөл, чиглэлийг тодорхойлох, төрийн өмчийг

хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах талаар цаашид авах арга хэмжээний санал боловсруулах;

3.1.2. Үндсэн чиглэлд заасан төрийн өмчит хуулийн этгээдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрчлөн зохион байгуулах;

3.1.3. Үндсэн чиглэлд заасан төрийн өмчит хуулийн этгээдийн энгийн болон нэмж гаргасан хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах ажлыг Засгийн газар зохион байгуулж, үр дүнг Улсын Их Хуралд тайлагнах;

3.1.4. Засгийн газар төрийн мэдлийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжихдаа хөрөнгийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хөрөнгө оруулагчдын сонирхол, санал болгож буй хуулийн этгээдийн үнэ цэнэ зэрэг хүчин зүйлүүдийг бодитой харгалзан тухайн жилийн жагсаалтыг батлах;

3.1.5. Компанийн үнэлгээг тогтоох, энгийн хувьцааг нийтэд санал болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хөндлөнгийн, хараат бус хувийн хэвшлийн компанийг нээлттэй сонгон шалгаруулах;

3.1.6. Үндсэн чиглэлд заасан төрийн өмчит хуулийн этгээдийг нээлттэй хувьцаат компани болгох, энгийн хувьцааг нийтэд санал болгох ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулах ажлыг төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчтэй хамтран хэрэгжүүлэх;

3.1.7. Олон нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх хуулийн этгээдийн зах зээлийн үнэлгээ, ирээдүйн үнэ цэнийг нарийвчлан тогтоосны үндсэн дээр хэрэгжүүлэх;

3.1.8. Нэмж хувьцаа гарган биржээр олон нийтэд нээлттэй худалдах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр компанийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, орлого олох үндсэн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах төсөл арга хэмжээнд зарцуулах.

3.2. Үндсэн чиглэлийн 3.1.7-д заасан үнэлгээний зардлыг тухайн хуулийн этгээд санхүүжүүлнэ.

ДӨРӨВ. БИРЖЭЭР НЭЭЛТТЭЙ ХУДАЛДАХ ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮД

4.1. Дараах төрийн өмчит хуулийн этгээдүүдийн энгийн хувьцааг нэмж гарган биржээр олон нийтэд нээлттэй худалдана:

4.1.1. "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн энгийн хувьцааны 49 хүртэлх хувийн хувьцааг нэмж гарган биржээр олон нийтэд нээлттэй арилжих бөгөөд төрийн эзэмшил 51 хувиас багагүй байх;

4.1.2. "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлсний дараа энгийн хувьцааны 66 хүртэлх хувийн хувьцааг нэмж гарган биржээр олон нийтэд нээлттэй арилжих бөгөөд төрийн эзэмшил 34 хувиас багагүй байх;

4.1.3. "Үндэсний давхар даатгал" ХК-ийн энгийн хувьцааны 34 хүртэлх хувийн хувьцааг нэмж гарган биржээр олон нийтэд нээлттэй арилжих, хувьцааг арилжаалахдаа ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй олон улсын хөрөнгө

оруулагчдад тэргүүн ээлжид санал болгон хуваарилах зарчим баримлах, төрийн эзэмшил 66 хувиас багагүй байх;

4.1.4. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааны 15 хүртэлх хувийг нэмж гарган биржээр нээлттэй арилжаалах бөгөөд төрийн эзэмшлийн хувийг 51 хувиас багагүй байх. Хувьцааг арилжаалахдаа олон улсын хөрөнгө оруулагчдад тэргүүн ээлжид санал болгон хуваарилах зарчмыг баримтална;

4.1.5. “Хөдөө аж ахуйн корпорац” ХХК-ийг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлсний дараа энгийн хувьцааны 49 хүртэлх хувийн хувьцааг нэмж гарган биржээр олон нийтэд нээлттэй арилжих бөгөөд төрийн эзэмшил 51 хувиас багагүй байх;

4.1.6. “Шивээ овоо” ХК-ийн энгийн хувьцаа 49 хүртэлх хувийг нэмэлт хувьцаа гарган биржээр нээлттэй худалдах арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд төрийн эзэмшил 51 хувиас багагүй байх;

4.1.7. “Багануур” ХК-ийн энгийн хувьцаа 24 хүртэлх хувийг нэмэлт хувьцаа гарган биржээр нээлттэй худалдах арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд төрийн эзэмшил 51 хувиас багагүй байх;

4.2. “МИАТ” ХК-ийн энгийн хувьцааны тодорхой хэсгийг стратегийн болон санхүүгийн хөрөнгө оруулагч нарт санал болгох, энгийн хувьцаа нэмж гарган олон улсын биржээр нээлттэй худалдах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ;

4.2.1. “МИАТ” ХК-ийн энгийн хувьцааны 10 хүртэлх хувийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагч нарт санал болгох замаар нээлттэй компани болгох;

4.2.2. “МИАТ” ХК-ийн төрийн мэдлийн энгийн хувьцааг худалдаж орсон орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх;

4.2.3. Хөрөнгө оруулагчийн менежментийн оролцоотойгоор компанийн үнэ цэнийг өсгөсний үндсэн дээр 34 хүртэлх хувийн нэмэлт хувьцаа олон улсын биржээр нээлттэй худалдах бөгөөд төрийн эзэмшил 51 хувиас багагүй байх;

4.3. “Төрийн банк” ХК-ийн төрийн эзэмшлийн энгийн хувьцааг 51 хувиас багагүй хэмжээнд үлдээж, Хадгаламжийн даатгалын корпорацын эзэмшлийн 45.03 хүртэлх хувийг биржээр нээлттэй худалдана;

4.3.1. Улсын Их Хурлаас баталсан үндсэн чиглэлийн хүрээнд Монгол банктай хамтран хөтөлбөр батлан хэрэгжүүлэх;

4.3.2. “Төрийн банк” ХК-ийн төрийн эзэмшлийн энгийн хувьцааг 51 хувиас багагүй байхаар тооцон, “Хадгаламжийн даатгалын корпорац”-ийн эзэмшлийн 45.03 хувийг биржээр нээлттэй худалдах. Ингэхдээ олон улсын мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгох.

4.4. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу биржээр олон нийтэд нээлттэй худалдана;

4.4.1. “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийг Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани болгох, Монгол Улсын иргэдэд хувьцаа эзэмшигчийн эрхийг бүрэн олгох, төрийн эзэмшлийн хувьцааны 10-аас доошгүй хувийг биржээр олон нийтэд нээлттэй арилжих;

4.4.2. Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолын 3-т заасны дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг Хөгжлийн банк болон Монгол банкнаас Худалдаа хөгжлийн банканд байршуулсан мөнгөн хөрөнгө, ногдол ашиг, вексель зэрэг эх үүсвэрээс суутган тооцох асуудлыг шийдвэрлэж, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт шилжүүлсний дараа энгийн хувьцааны 10-аас доошгүй хувийг биржээр олон нийтэд нээлттэй арилжих;

4.4.3. Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолын 3-т заасны дагуу Монголросцветмет ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг Хөгжлийн банк болон Монгол банкнаас Худалдаа хөгжлийн банканд байршуулсан мөнгөн хөрөнгө, ногдол ашиг, вексель зэрэг эх үүсвэрээс суутган тооцох асуудлыг шийдвэрлэж, “Эрдэнэс критикал минералс” төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт шилжүүлсний дараа энгийн хувьцааны 10-аас доошгүй хувийг биржээр олон нийтэд нээлттэй арилжих;

4.5. Эрчим хүч үйлдвэрлэх болон түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах төрийн өмчит компаниудын энгийн хувьцааны 49 хүртэлх хувийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах болон өөрчлөн зохион байгуулна;

4.5.1. "Дулааны III цахилгаан станц" ТӨХК-ийн энгийн хувьцааны 49 хүртэлх хувийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй арилжаалан нээлттэй хувьцаат компани болгох бөгөөд төрийн эзэмшил 51 хувиас багагүй байх;

4.5.2. "Дулааны IV цахилгаан станц" ТӨХК-ийн энгийн хувьцааны 49 хүртэлх хувийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй арилжаалан нээлттэй хувьцаат компани болгох бөгөөд төрийн эзэмшил 51 хувиас багагүй байх;

4.5.3. "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн энгийн хувьцааны 49 хүртэлх хувийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй арилжаалан нээлттэй хувьцаат компани болгох бөгөөд төрийн эзэмшил 51 хувиас багагүй байх;

4.5.4. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн цахилгаан дамжуулах сүлжээг "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанид нэгтгэн зохион байгуулсны үндсэн дээр энгийн хувьцааны 49 хүртэлх хувийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй арилжаалан нээлттэй хувьцаат компани болгох бөгөөд төрийн эзэмшил 51 хувиас багагүй байх;

4.5.5. "Дарханы дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн энгийн хувьцааны 49 хүртэлх хувийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй арилжаалан нээлттэй хувьцаат компани болгох бөгөөд төрийн эзэмшил 51 хувиас багагүй байх;

4.5.6. "Амгалан дулааны станц" ТӨХК-ийн энгийн хувьцааны 49 хүртэлх хувийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй арилжаалан нээлттэй хувьцаат компани болгох бөгөөд төрийн эзэмшил 51 хувиас багагүй байх;

4.6. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, арилжих хуулийн этгээдүүд

4.6.1. "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах;

4.6.2. "Цемент шохой" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах;

4.6.3. “Монгол шуудан” хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр арилжих.

4.6.4. “Багануур дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах;

4.6.5. “Налайхын дулаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах;

4.6.6. “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах;

4.6.7. “Ховд дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах;

4.6.8. “Улаангомын дулааны II станц” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах;

ТАВ. ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ӨӨРЧЛӨХ.

5.1. “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг олон улсын менежментийн багаар удирдуулах, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлэх;

5.2. Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлах, эрчим хүчний салбарыг чөлөөт зах зээлийн зарчимд шилжүүлж, үнэ тарифыг зохистой түвшинд хүргэн, цаашид тогтмол индексжүүлэх тогтолцоог нэвтрүүлж, салбарын эрх зүйн орчныг шинэчлэх;

5.2.1. “нэг худалдан авагчийн загвар”-ыг өрсөлдөөнт зах зээлийн загварт шилжүүлэх;

5.2.2. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн цахилгаан дамжуулах сүлжээ болон “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн системийн операторын үүргийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанид нэгтгэн зохион байгуулах;

5.2.3. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн цахилгаан эрчим хүчээр хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийг түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс салгаж бие даасан хуулийн этгээд болгох;

5.3. Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Мэдээлэл технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрыг мэдээллийн технологийн салбарын “Судалгаа, бизнес хөгжүүлэлтийн төв” болгон өөрчлөн зохион байгуулж, холбогдох яамны харьяалалд шилжүүлэх;

5.4. “Авто импекс” хувьцаат компанийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд татан буулгаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын шийдвэрээр битүүмжилж, хураагдсан хөрөнгийг “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын мэдэлд шилжүүлэн холбогдох өр төлбөрийг нь барагдуулах;

5.5. “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор” ХХК-ийг “Хөдөө аж ахуйн корпораци” ХХК-д нэгтгэн зохион байгуулах;

5.6. Авто замын засвар, арчлалтын үйл ажиллагаа эрхэлж буй “Автозам засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компанийн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх: Үүнд:

а/Авто замын засвар, арчлалтын үйл ажиллагаа эрхэлж буй “Автозам засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компанийг татан буулгаж, “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт нэгтгэн өөрчлөн зохион байгуулах.

--o0o--

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАХ СУДАЛГАА

Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэлийн зорилго нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулах, төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангахад оршино.

Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл нь салбар тус бүрд байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах ажлын чиглэлийг тодорхойлж байгаа баримт бичиг бөгөөд энэхүү баримт бичгийг Монгол Улсын төрийн захиргааны болон холбогдох бусад байгууллага, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн (Төрийн өмчийн талаарх Улсын Их Хурлын бүрэн эрх) 8 дугаар зүйлийн 8.5-д “Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг батлах, түүнд өөрчлөлт оруулах.”... гэж заасан. Энэ хүрээнд Улсын Их Хурлын 2001 онд баталсан “Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл”, 2005 онд баталсан “Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл, 2010 онд баталсан “Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл, 2013 онд баталсан “Төрийн өмчийг 2013-2014 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, 2015 онд баталсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийг тус тус баталсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна. 8.1.1.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах;....., 13 дугаар зүйлийн 13.1-д Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг энэ хуулийн 12.1.2-т заасан аргачлалын дагуу тодорхойлно гэж заасан.

1. Асуудалд дүн шинжилгээ хийх.

Өмч хувьчлал нь нэг тогтолцооноос нөгөө тогтолцоонд шилжихтэй холбоотой нийгэм, эдийн засгийн бусад томоохон арга хэмжээтэй зэрэгцэн хэрэгжиж, хувийн хэвшлийг хөгжүүлэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах, бага зардлаар чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болох, өмчийн олон талт харилцаа хөгжих, эдийн засагт хувийн хэвшлийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийг нэмэгдүүлэх түүхэн үүргээ 35 жил гүйцэтгэж ирсэн үйл явцыг судалсны үндсэн дээр Монгол Улс дахь өмч хувьчлалын үйл явцыг үндсэн таван үе шат болгон авч үзлээ. Үүнд:

- Өмч хувьчлалын I үе буюу 1991-1995 он
- Өмч хувьчлалын II үе буюу 1996-2000 он
- Өмч хувьчлалын III үе буюу 2001-2004 он
- Өмч хувьчлалын IV үе буюу 2005-2016 он
- Өмч хувьчлалын V үе буюу 2017-2025 он

1991-1995 онд нийт 919 аж ахуйн нэгжийн 12.6 тэрбум төгрөгийн хөрөнгө, 1996-2000 онд битүүмжилсэн дуудлага худалдаагаар 6.6 тэрбум төгрөгөөр нийт 75 аж ахуйн нэгж, нийтийн дуудлага худалдаагаар 40.8 тэрбум төгрөгөөр 847 аж ахуйн нэгжийг хувьчилсан байна. 2001-2004 онд 83 аж ахуйн нэгжийн 62.6 тэрбум төгрөг, 2005-2016 онд 89 аж ахуйн нэгжийн 102.4 тэрбум, 2017 онд нийт 4 аж ахуйн нэгжийн 16.2 тэрбум төгрөг, 2022 онд Төрийн банкны 5.71 хувийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд нээлттэй арилжихад 7306 хувь хүн, аж ахуйн нэгжээс 67.3 тэрбум төгрөгийн санал ирүүлж, 25.4 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн, Монголын хөрөнгийн биржийн 34 хувийн хувьцааг 7414 хувь хүн, аж ахуйн нэгжээс 57.8 тэрбум төгрөгийн санал ирүүлж, 11.9 тэрбум төгрөгөөр тус тус арилжсан. 1991 оноос хойш 278.5 тэрбум төгрөгийн дүн бүхий 2,019 аж ахуйн нэгж, үл хөдлөх хөрөнгө, хувьцааг бүхэлд нь эсвэл тодорхой хувийг нээлттэй дуудлага худалдаа, хөрөнгийн биржээр дамжуулах болон бусад холбогдох арга хэлбэрээр худалдан, хувьчилсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ...” гэж хуульчилсан, мөн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, ...эрхтэй.”

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Ухаалаг засаглалын зорилгод “Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна.”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.4.2.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх, төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж, хяналтыг сайжруулах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчилнэ.”

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын Төрийн бүтээмжийн сэргэлтэд “Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.” гэж тус тус заасан.

“Шинэ итгэл-Эрс шинэтгэл” “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд төрийн өмчит компанийн засаглалыг олон улсын компанийн засаглалын зарчимд нийцүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх, Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны бүртгэл,

мэдээллийн ил тод байдлыг бүрэн ханган төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалтын цахим шилжилтийг хийх зорилтыг тусгасан.

Иймд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулах, төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангах, улс орны эдийн засагт олон нийтийн болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр компанийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, орлого олох үндсэн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах төсөл арга хэмжээнд зарцуулах, компанийн засаглал сайжирч, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, төр болон хувийн хэвшлийн түншлэлийн зохистой хэлбэрийг бий болгох асуудал чухлаар тавигдаж байна.

2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох.

а). Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэлийн зорилго нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулах, төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангахад оршино.

Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл нь /цаашид “Үндсэн чиглэл” гэх/ салбар тус бүрд байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг хувьчлах, өөрчлөн байгуулах талаар хийх ажлын чиглэлийг тодорхойлж байгаа баримт бичиг бөгөөд энэхүү баримт бичгийг Монгол Улсын төрийн захиргааны болон холбогдох бусад байгууллага, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

б). Улсын Их Хурлын 2001 онд баталсан “Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл”, 2005 онд баталсан “Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл, 2010 онд баталсан “Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл, 2013 онд баталсан “Төрийн өмчийг 2013-2014 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, 2015 онд баталсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг нийтэд нь авч үзэхэд хэрэгжилт 37 хувьтай байна.

Иймд дээр дурдсан үндсэн чиглэлүүдийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч, үндсэн чиглэлүүдэд туссан боловч хэрэгжээгүй хуулийн этгээдүүдийг Улсын Их Хурал болон Засгийн газраас өгсөн чиглэл, үзэл баримтлалын хүрээнд үе шаттайгаар хэрэгжүүлэх талаар санал боловсруулан, шийдвэрлүүлэх нь зүйтэй.

3. Асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулах.

Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 03 дугаар тогтоолоор “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдах ажлыг эрчимжүүлэх, мөн зах зээл дэх төрийн оролцоог багасгах, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, ил тод байдлыг ханган компанийн засаглалыг сайжруулах зорилгоор хувьцааг нь олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөх мэдүүлэхийг чиглэл болгосон.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 244 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах, УИХ-ын Үйлдвэржилтийн байнгын хорооноос өгсөн чиглэлийн хүрээнд томоохон аж ахуйн нэгжүүдийг нэмж оруулан, төрийн өмчит хуулийн этгээдийг олон нийтийн шууд хяналтад оруулах бодлогын хүрээнд хуулийн этгээдийн энгийн хувьцааг нэмж гаргах, хувьцаа гаргах бэлтгэл хангах, биржээр олон нийтэд нээлттэй худалдах, нээлттэй хувьцаат компани болгож, өөрчлөн байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах шаардлага гарсан.

Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээдүүдийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг арилжина гэж заасны дагуу Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй арилжаалан нээлттэй хувьцаат компани болгох стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа “Эрдэнэставан толгой” хувьцаат компанийн энгийн хувьцааны 10 хувийг биржээр олон нийтэд нээлттэй арилжихаар үндсэн чиглэлд тусгасан.

Эрчим хүчний реформын хүрээнд эрчим салбарын бүтэц, төрийн өмчит компанийн засаглал, менежментийг сайжруулах чиглэлээр холбогдох судалгаа, зөвлөмжийн хүрээнд эрчим хүчний зарим компаниудын энгийн хувьцааны 34 хүртэлх хувийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй арилжаалан нээлттэй хувьцаат компани болгох, төрийн эзэмшил 66 хувиас багагүй байхаар тооцон тусгасан.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн цахилгаан эрчим хүчээр хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийг түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс салгаж бие даасан хуулийн этгээд болгон зохион байгуулахаар тусгасан.

“МИАТ” ХК-ийн энгийн хувьцааны 10 хүртэлх хувийн хувьцааг хаалттай хүрээнд стратегийн хөрөнгө оруулагч нарт санал болгож, төрийн мэдлийн энгийн хувьцааг худалдаж орсон орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх, хөрөнгө оруулагчийн менежментийн оролцоотойгоор компанийн үнэ цэнийг өсгөсний үндсэн дээр 34 хүртэлх хувийн нэмэлт хувьцаа олон улсын бирж дээр гаргах замаар нээлттэй компани болгох, “Төрийн банк” ХК-ийн төрийн эзэмшлийн энгийн хувьцааг 51 хувиас багагүй байхаар тооцон, “Хадгаламжийн даатгалын корпорац”-ийн эзэмшлийн 45.03 хувийг биржээр нээлттэй худалдах, “Хадгаламжийн даатгалын корпорац”-ийн

хөрөнгө оруулсан санхүүжилтээс давсан орлогыг төсөвт төвлөрүүлэхээр тус тус тусгасан.

4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах.

- Төрийн өмчийг хувьчлах талаар Улсын Их Хурлаас баталсан үндсэн чиглэлийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх.
- Хуулийн тогтоомжийн төсөл боловсруулах: “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах, төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийг өмнөх жилүүдэд боловсруулж байсан туршлагад тулгуурлан боловсруулах.

5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх

- Нэгдүгээр хувилбар: Төрийн өмчийг хувьчлах талаар Улсын Их Хурлаас баталсан үндсэн чиглэлийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх.

Улсын Их Хурлын 2001 онд баталсан “Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл”, 2005 онд баталсан “Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл, 2010 онд баталсан “Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл, 2013 онд баталсан “Төрийн өмчийг 2013-2014 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, 2015 онд баталсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-дийн хэрэгжилтийг нийтэд нь авч үзэхэд 37 хувьтай байна.

Төрийн өмчийг хувьчлах талаар Улсын Их Хурлаас баталсан үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх боломжтой хэдий ч өмнөх Улсын их хурал, Засгийн газар боловсруулсан тул одоогийн Улсын Их Хурал, Засгийн газрын бодлоготой зөрчилдсөн зүйлүүд байгаа тул хэрэгжих боломж хязгаарлагдмал.

Иймд дээрх үндсэн чиглэлүүдийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч, үндсэн чиглэлүүдэд туссан боловч хэрэгжээгүй хуулийн этгээдүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх талаар санал боловсруулан, шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

Хоёрдугаар хувилбар: Хуулийн тогтоомжийн төсөл боловсруулах: “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2025-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах, төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийг өмнөх жилүүдэд боловсруулж байсан туршлагад тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэх бүрэн боломжтой.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Ухаалаг засаглалын зорилгод “Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна.”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.4.2.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх, төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж, хяналтыг сайжруулах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчилнэ.”

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын Төрийн бүтээмжийн сэргэлтэд “Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 03 дугаар тогтоолоор “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдах ажлыг эрчимжүүлэх, мөн зах зээл дэх төрийн оролцоог багасгах, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, ил тод байдлыг ханган компанийн засаглалыг сайжруулах зорилгоор хувьцааг нь олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөх мэдүүлэхийг чиглэл болгосон.

Иймээс “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл”-ийг өмнөх жилүүдэд боловсруулж байсан туршлагад тулгуурлан Улсын Их Хурал болон Засгийн газраас өгсөн чиглэл, үзэл баримтлалыг тусган шинэчлэн боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

6. Зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх.

Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр олон улсын хөгжлийн байгууллагууд болох Азийн Хөгжлийн Банк (ADB), Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (EBRD), Олон Улсын Валютын Сан (IMF), Эдийн Засаг, Хамтын Ажиллагааны Хөгжлийн Байгууллага (OECD), АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID), БНХАУ-ын Төрийн Өмчийн Хяналт, Удирдлагын Хороо (SASAC), Сингапур Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг (SCE), Сингапур Улсын TEMACEK холдинг, TEMACEK фаундэйшн зэрэг байгууллагуудтай хамтарсан төсөл хөтөлбөр, сургалт семинар, техникийн туслалцааны төслүүдийг 2022-2025 онуудад хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эдийн засаг, хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага: (OECD)

Эдийн засаг, хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD)-ын Төрийн өмчит компанийн засаглал, өмч хувьчлалын 2023 оны 04 дүгээр сард Парис хотод зохион байгуулагдсан 40 дэх удаагийн уулзалт, 2024 оны 10 дугаар сард зохион байгуулагдсан 43 дахь удаагийн уулзалт, семинар, 2023 оны 12 дугаар сард БНХАУ-д зохион байгуулагдсан Төрийн өмчит компанийн засаглал, өмч хувьчлалын Азийн бүсийн 16 удаагийн уулзалт, семинарт оролцсон. Уулзалтын хүрээнд OECD-ийн гишүүн 38 улсаас гадна БНХАУ, Филиппин улс, Казакстан улс, Индонези улс, Хорват улс болон Европын холбоо, Олон Улсын Валютын сан, Европын сэргээн босголт хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудын төлөөлөлтэй уулзаж, Монгол Улсын төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах асуудлаар санал солилцож, тодорхой техникийн туслалцааны төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр тогтсон. Мөн хурлаар Төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, төрийн өмчит компаниудын өмчлөлийн оновчтой бодлого хэрэгжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг ил тод нээлттэй болгох, өрсөлдөөнийг дэмжих, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, тогтвортой хөгжлийн бодлогыг дэмжих, төрийн өмчит

компаниудын комплайнсын асуудал, улс орнуудын өмчлөлийн туршлага, компанийн засаглалтай холбоотой шинэчлэлийн жишээнүүд, ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүдийг мэргэшүүлэх, ТУЗ-ийн үйл ажиллагааны талаар, ТӨК-ийн ногдол ашгийн бодлого зэрэг асуудлаар хуралд оролцсон улс бүр өөрийн авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, туршлага, цаашид хэрэгжүүлэхээр зорьж буй зорилт, мөн OECD-ээс 2015 онд гаргасан Төрийн өмчит компанийн засаглалын талаарх зөвлөмжийн хэрэгжилт, түүнтэй уялдуулан гаргасан бусад зөвлөмж, гишүүн болон гишүүн бус орнуудад хийгдсэн техникийн туслалцаа, түүний зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг танилцуулсан. OECD-Төрийн өмчит компанийн засаглалын талаарх 2024 оны 10-р сар шинэчлэн баталсан Төрийн өмчит компанийн засаглалын удирдамжтай танилцсан.

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк: (EBRD)

ТӨБЗГ-ын зүгээс Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах асуудлаар Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай 2023-2024 онуудад хэд хэдэн уулзалт, хэлцэл хийсний үр дүнд төрийн өмчит үйлдвэрийн газар, компаниудын засаглал, үр өгөөж, өмчлөлийн бүтцийг сайжруулах асуудлын хүрээнд 2 шатны 5 төрлийн техникийн туслалцааг буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэхээр тогтсон.

Тус банкны зүгээс техникийн буцалтгүй туслалцааны төслийн хүрээнд эрчим хүчний салбарын загвар компаниар “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК, зам тээврийн салбарын загвар компаниар “МИАТ” ТӨХК, уул уурхайн салбарын загвар компаниар “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-г сонгон асуумжийн аргаар тодорхой судалгаа, шинжилгээний ажлуудыг 2024 оны 06 дугаар сараас хойш гүйцэтгэж 2025 оны 09 дүгээр сард үнэлгээний нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт танилцуулсан.

Тус техникийн туслалцааны төслийн баг нь OECD-ийн 2024 онд шинэчлэгдэн батлагдсан төрийн өмчит компанийн засаглалын удирдамж, зарчмын дагуу манай улсын ТӨК-уудын засаглалын нөхцөл байдал тус удирдамжид хэрхэн нийцэж буй талаарх үнэлгээг гаргасан.

Мөн төслийн баг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах тухай анхдагч хуулийн төслүүдэд саналаа өгсөн.

Улсын Их Хурлаас төрийн өмчит компанийг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжих, өмч хувьчлалын талаар үндсэн чиглэлийн төсөлд саналаа өгсөн.

ТӨБЗГ-ын зүгээс төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт компаниудын 2022-2024 оны санхүүгийн тайланг нэгтгэн тус банкны дотоодын зөвлөх байгууллагад хүргүүлсэн ба Европын сэргээн босголт хөгжлийн банкны зүгээс манай улсын ТӨК-уудыг тоон буюу санхүү, эдийн засгийн үзүүлэлтээр, чанарын буюу санхүүгийн бус үзүүлэлтүүдээр үнэлэх тодорхой аргачлалыг боловсруулан танилцуулсан. Мөн ТӨК-уудыг тус банкны дотоодын болон гадаадын зөвлөхүүдээс боловсруулсан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу ангилах, ангилал тус бүрд тохирсон өмчлөлийн бодлого хэрэгжүүлэх талаар зөвлөмжийг боловсруулан танилцуулсан.

Олон Улсын Валютын Сан: (IMF)

Сангийн яам, Олон Улсын Валютын Сантай 2023-2024 онуудад ТӨК-уудаас төсөвт нөлөөлж буй эрсдэлийн талаар судалгааны ажлын хүрээнд 2025 онд ТӨК-уудаас манай улсын төсөвт нөлөөлж буй судалгааны тайланг боловсруулан танилцуулсан.

Азийн Хөгжлийн Банк: (ADB)

2024 онд Азийн хөгжлийн банкны төлөөлөлтэй уулзаж тус банкны зүгээс цаашид Монгол Улсын төрийн өмчит компанийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлуудын талаар санал солилцож, төрийн өмчит компанийн хууль эрх зүй, засаглалын нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх төлөвлөж буй ажлуудын талаар мэдээлэл өгч, санал солилцсон. Азийн хөгжлийн банкны зүгээс Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран Баялагийн сангийн хэрэгжилт, төрийн өмчийн шинэчлэлд дэмжлэг үзүүлэх техникийн туслалцааны төслийг хамтран хэрэгжүүлж байна.

Тус төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны гадаад болон дотоод зөвлөхүүд салбар бүрийн төрийн өмчит компаниудын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан, уулзалт хийж, цаашид тус банкны зүгээс гаргах зөвлөмжийн талаар асуумж асууж, холбогдох судалгааг хийсэн, мөн төрийн өмчит компаниудын удирдлагуудад компанийн засаглалын олон улсын туршлага, цаашдын чиг хандлагын талаар сургалт зохион байгуулсан. Тус банкны тайлан, зөвлөмж 2026 оны 06 дугаар сард эцэслэн гарахаар хүлээгдэж байна.

БНХАУ-ын төрийн өмчийн хяналт, удирдлагын хороо: (SASAC)


БНХАУ-ын Төрийн өмчийн хяналт, удирдлагын хороо (SASAC)-той 2023 оноос хойш хамтран ажилласны үр дүнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 06 дугаар сард тус улсад айлчилсан айлчлалын үеэр Хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Санамж бичгийн хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Төрийн өмчийн хяналт, удирдлагын хороотой хамтран тус улсын ӨМӨЗО-ны Хөх хот хамтарсан форумыг 2023 оны 09 дүгээр сарын 04-ны өдрөөс 08-ны өдрүүдийн хооронд амжилттай зохион байгуулсан. Тус уулзалтад Монгол Улсаас төрийн өмчит 13 хуулийн этгээд, БНХАУ-ын талаас төрийн болон орон нутгийн өмчит 216 компани оролцож цаашдын хамтын ажиллагааны эхлэлийг тавьсан ба цаашид хоёр улсын төрийн өмчит компаниудын хамтын ажиллагааг өргөжүүлэхээр ажиллаж байна.

Сингапур Улсын хамтын ажиллагааны агентлаг: (SCE)

Сингапур Улсын Хамтын ажиллагааны агентлагтай тус улсын компанийн сайн засаглалын туршлагыг нэвтрүүлэх, судлах талаар хэд хэдэн удаагийн уулзалтуудыг зохион байгуулсан ба уулзалтын хүрээнд тус улсын TEMASEK холдинг, TEMASEK фаундэйшн талаар нарийвчлан судалж, холбогдох судалгааны үр дүнг ТӨК-уудын өмчлөлийн бодлогод тусгахаар ажиллаж байна. Мөн хамтын ажиллагааны хүрээнд загвар төсөл буюу загвар компаниар “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийг сонгон, тус компанийг Олон улсын хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй хувьцаат компани болгох шийдлийг судлан ажиллаж байна.

АНУ-ын олон улсын хөгжлийн агентлаг: (USAID)

Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын хөгжлийн агентлаг /USAID/ “Монголын эрчим хүчний засаглал” хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцаж, гарсан тайлан, зөвлөмжийг манай улсын эрчим хүчний салбарын ТӨК-ууд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.



Австрали, Словак улсад төрийн өмчийн асуудлыг Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн яам, Канад, Ирланд, Норвег, Герман, Англи, Чех, Итали, Солонгос, Польш, Швед, Швейцар зэрэг улсуудад төрийн өмчийн асуудал эрхэлсэн яам, Грек, Турк зэрэг улсуудад Өмч хувьчлалын асуудал эрхэлсэн агентлаг, Австри, Бельги, Финланд, Франц, Унгар, Португал, Испани зэрэг улсуудад төрийн өмчийн асуудал эрхэлсэн агентлаг хариуцан ажилладаг.

ЭНЭТХЭГ

Энэтхэгийн нийт 290 төрийн өмчийн компанийн 243 нь 100 хувь төрийн өмчит, 47 нь төрийн өмч давамгайлсан төрийн өмчит компани хэмээн Бомбойн хөрөнгийн биржид бүртгэгдсэн байдаг. Төрийн өмчит компаниудыг (Энэтхэгт, төвийн олон нийтийн бүсийн аж ахуйн нэгж ТОНБААН) нь холбогдох яам, ерөнхий дарга, аудитор, төлөвлөлтийн хороо, төвийн сонор сэрэмжийн (хяналтын) хороо, улсын их хурлын гүйцэтгэлийн менежментийн салбар, Төрийн өмчит компанийн санамж бичгийг хянах дээд эрх мэдлийн хороод зохицуулдаг.

ИНДОНЕЗ

Индонезийн төрийн өмчит компани нь хоёр төрөлд ангилагддаг ба (1) Persero буюу хамгийн багадаа 51 хувь нь Индонезийн засгийн газар эзэмшил ба ашиг олох зорилго бүхий хувьцаат компани (2) Perum ашиг олохын зэрэгцээ өндөр чанартай үйлчилгээ, бараа бүтээгдэхүүн санал болгох замаар олон нийтийн ашгийг дээдэлдэг, капитал нь хувьцаанд хуваагдаагүй компани юм. Төрийн өмчит аж ахуйн яам нь Persero-д төрийн зүгээс хувьцаа эзэмшигчээр Индонезийн засгийн газрыг төлөөлж сонгогддог.

КАЗАКСТАН

Казакстанд нийт 6441 аж ахуйн нэгж байдаг ба үүний 594 буюу 8 хувь нь төрийн өмчит хувьцаат болон хязгаарлагдмал хариуцлагатай компани ба 27 аж ахуйн нэгж үндэсний холдинг компаниудаас бүрддэг. Самрук-Казияна нь хараат бус хөрөнгийн сан ба дараах хэд хэдэн салбаруудад эргэлддэг томоохон стратегийн хөрөнгүүдийг удирддаг. Үүнд: нефть, байгалийн хий, тээвэрлэлт ба харилцаа холбоо, атомын үйлдвэр, уул уурхай, цахилгаан болон химийн үйлдвэрлэл орно.

ӨМНӨД СОЛОНГОС

Стратеги болон Санхүүгийн яам 316 олон нийтийн институт (ТӨК)-г байгуулсан бөгөөд үүнд 30 олон нийтийн корпорац, 86 хагас Засгийн газрын байгууллага болон 200 гаруй ангилагдаагүй олон нийтийн институт багтдаг. Өмнөд Солонгосын ерөнхий сайдын оффис, 21 яам, 13 агентлагууд эдгээр олон нийтийн байгууллагын бизнес болон үйл ажиллагааны голлох стратеги болон зорилтуудыг гаргадаг.

ПАКИСТАН

Пакистанд тухайн салбарын холбогдох сайдууд 170-аад төрийн өмчит компанийн хэтийн зорилго, гүйцэтгэлийн хяналт болон мэдээллийн ил тод байдал зэргийг хариуцан ажилладаг ба захиргааны байгууллагууд эдгээр салбарын үйл ажиллагааны стандартыг тогтоодог. Харин үнэт цаас арилжааны хороо нь эдгээр төрийн өмчит компанийн ил тод байдлын мэдээллийг тогтмол гаргах үүрэгтэй.

Олон улсын туршлагаар үзэхэд төрийн өмчийн удирдлага, менежментийн арга барилыг шинэ шатанд гаргах, шинэ стратеги буюу IPO нэмэлт хувьцаа гарган хувьчлах, төрийн хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, засаглалын ил тод, нээлттэй болгох үндсэн зарчмуудыг баримталж байна.

Манай улсад:

1991-1996 онд өмч хувьчлал эхэлсэн ба Засгийн газар, Нийслэл, аймаг, дүүргийн Өмч хувьчлалын комисс хувьчлалыг явуулж ирсэн. 1996 оны 7 дугаар сарын 31-нд Төрийн өмчийн хороо байгуулагдсанаар Монголын эдийн засаг, төрийн албаны түүхэнд урьд өмнө байгаагүй чиг үүрэг, эрх, бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа 20 жил явуулсан. Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 5 дугаар тогтоолоор Төрийн өмчийн хороог татан буулгаж, чиг үүргийг Сангийн яаманд шилжүүлсэн.

Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

2025 оны байдлаар уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц, зам, тээвэр, банк, санхүү, мэдээлэл харилцаа зэрэг салбаруудад толгой компани 84, тэдгээрийн охин, хараат компани 17 нийт 101 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрууд үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээр компани, үйлдвэрийн газруудаас 100% төрийн өмчийн 73, төрийн өмчийн оролцоотой 22, олон нийтийн нээлттэй хувьцаат компани 6 байна. Хариуцлагын хэлбэрээр нь задалбал төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ) – 15, төрийн өмчит хувьцаат компани (ТӨХК) – 28, төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани (ТӨХХК) – 30, төрийн өмчийн оролцоотой хаалттай хувьцаат компани (ХК) – 2, төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) – 19, төрийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн нийгэмлэг (ХНН) – 1, төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компани (ХК) – 2 байна. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр нь авч үзвэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (түүний харьяанд “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрчист Монгол” ХХК болон тэдгээрийн харьяа компаниудыг оролцуулаад нийт 41 ТӨК), Эрчим хүчний яам (түүний харьяанд 28 ТӨК), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (түүний харьяанд 14 ТӨК),

Сангийн яам (түүний харьяанд 5 ТӨК), Зам, тээврийн яам (түүний харьяанд 5 ТӨК), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (түүний харьяанд 4 ТӨК), Эдийн засаг, хөгжлийн яам (түүний харьяанд 2 ТӨК), Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (түүний харьяанд 1 ТӨК), Хууль зүй, дотоод хэргийн яам (түүний харьяанд 1 ТӨК) зэрэг нийт 11 хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нар байна.

Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрууд нь 2024 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн нэгтгэсэн дүнгээр нийт хөрөнгө 59.4 их наяд төгрөг буюу ДНБ-ний 74.3% ("Эрдэнэс тавантолгой" ХК, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ийн дүнг хасвал ДНБ-ний 35.9%), нийт орлого 26.0 их наяд төгрөг буюу ДНБ-ний 32.5% ("Эрдэнэс тавантолгой" ХК, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ийн дүнг хасвал ДНБ-ний 18.5%), нийт өр төлбөр 22.9 их наяд төгрөг буюу ДНБ-ний 28.6% ("Эрдэнэс тавантолгой" ХК, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ийн дүнг хасвал ДНБ-ний 18.7%)-тай тус тус тэнцэж байна. Нийт хөрөнгийн 63% буюу 37.4 их наяд төгрөг, нийт орлогын 63% буюу 16.4 их наяд төгрөг, нийт өр төлбөрийн 29% буюу 6.6 их наяд төгрөгийг уул уурхайн салбарын төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын дүн эзэлж байна.

Сүүлийн 5 жилд буюу 2021-2025 онуудад төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын чиг үүргийн давхардлыг арилгах, үр ашгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах арга хэмжээг авч 135 байсан төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын тоог 101 болгон 34-өөр буюу 25.2%-иар бууруулаад байна.

Мөн төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын хөрөнгийн өгөөж 2021 онд 1.94% байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 9.63% болж нэмэгдсэн, 2021 онд 1 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 5.7 их наяд төгрөг болж өссөн үзүүлэлттэй байна. Гэвч нийт орлогын 56%, цэвэр ашгийн 89%-ийг уул уурхайн салбарын "Эрдэнэс тавантолгой" ХК болон "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ийн дүн эзэлж байгаа тул цаашид төрийн өмчит компанийн шинэчлэлийн бодлогыг үргэлжүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Цаашид төрийн өмчит компаниудад баримтлах бодлого, чиглэлийг тодорхой болгох үүднээс төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудыг тодорхой шалгуурын хүрээнд ангилж авч үзэх, тэдгээрийн ангилалын хүрээнд төрийн зүгээс тухайн компанид оролцох өмчлөлийн бодлогыг ангилал тус бүрийн онцлогт тулгуурлан ялгамжтай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дээрх ажлын хүрээнд "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл"-ийн төсөлд 18 төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын төрийн мэдлийн 10-66 хүртэлх хувийн хувьцааг олон нийтэд хөрөнгийн биржээр дамжуулан санал болгон худалдаж нээлттэй хувьцаат компани болгох, 8 төрийн өмчит компанийн хувьцааг бүхэлд нь худалдах, 7 төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудыг нэгтгэх, нийлүүлэх, бүтцийн өөрчлөлт хийх, саналыг тусгаад байна.

Цаашид төрийн өмчит хуулийн этгээлийг биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын тоо нийт дүнгээр 101 байсныг 19-ээр буюу 18.8%-иар бууруулж 82 болгохоор төлөвлөж байна.

Стратегийн ач холбогдолтой болон бусад томоохон төрийн өмчийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, үнэ цэн бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нийлүүлэх замаар өгөөжийг өсгөх, Үндэсний баялгийн санг бүрдүүлэн Монгол Улсын эдийн засагт хувь нэмэр оруулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасан уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын бүх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд буюу стратегийн ордод үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит компаниудыг “Эрдэнэс Монгол” ХХК-д нэгтгэж, нэгдлийн зарчмаар ажиллуулж, Үндэсний баялгийн сангийн орлого төвлөрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байна.

Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагат харьяалж буй төрийн өмчит үйлдвэрийн газрууд болон “Эрдэнэс монгол” нэгдлээс бусад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудыг төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор захиргаа хүний нөөц, санхүү, олон нийттэй харилцах, маркетинг болон үнэлгээ, мониторинг, гадаад харилцаа зэрэг ижил төрлийн зарим үүргийг нэгтгэж, зардал бууруулах, нэгдсэн менежмент хэрэгжүүлж, хяналт тавих үүрэг бүхий “Эрчист Монгол” ХХК-ийг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр байгуулж, зам, тээвэр, хөдөө аж ахуй, санхүү, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компанийг нэгтгэн харьяанд ажиллуулж байна.

7. Зөвлөмж боловсруулах.

Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах, төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийг өмнөх жилүүдэд боловсруулж байсан туршлагад тулгуурлан Улсын Их Хурал болон Засгийн газраас өгсөн чиглэл, үзэл баримтлалыг тусган шинэчлэн боловсруулахыг зөвлөмж болгож байна. “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл”-ийг боловсруулахдаа дараах үндсэн зарчмыг баримтлах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- Төрийн өмчит хуулийн этгээдийг олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгох замаар ил тод байдлыг хангаж, санхүүгийн сахилга батыг сайжруулж, олон нийтийн хяналтад оруулах, төрийн мэдлийн энгийн хувьцааг худалдаж орсон орлогын тодорхой хувийг улсын төсөвт төвлөрүүлэх, өрсөлдөөний зарчмаар хувийн хэвшил бие даан гүйцэтгэх боломжтой салбарт төр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхгүй байж, тухайн салбарыг зах зээлийн зарчмаар хөгжих боломжийг хангах, зах зээл дэх төрийн оролцоог багасгах, тухайн салбарт бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тариф зах зээлийн зарчмаар тогтох боломжийг нэмэгдүүлэх, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр арилжаалах үйл ажиллагааг хууль, эрх зүйн хүрээнд ил тод, нээлттэй хэрэгжүүлж, олон нийт, иргэдийн оролцоог хангасан нээлттэй компани болгох.
- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээдүүдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдан Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6-д “...стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээдүүдийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг арилжина...” гэж заасныг хэрэгжүүлэх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 34-өөс дээш хувийг аливаа этгээд дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшихийг хориглох.

- Эрчим хүч үйлдвэрлэх болон түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй арилжаалан нээлттэй хувьцаат компани болгох, Эрчим хүчний компаниудын төрийн эзэмшил 51 хувиас багагүй байх, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн цахилгаан эрчим хүчээр хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийг түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс салгаж бие даасан хуулийн этгээд болгох.
- Улс орны эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор хувийн хэвшлийн үр өгөөж бүхий хөрөнгө оруулалтыг татах, төр, хувийн хэвшлийн хооронд бизнесийн өрсөлдөөнийг бууруулан харилцан ашигтай түншлэлийн хэлбэр, тэнцвэртэй эдийн засгийн бүтцийг бий болгох.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	+ Үгүй	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	+ Тийм	Үгүй	
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцоо боломжийг бүрдүүлсэн эсэх	+ Тийм	Үгүй	
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	+ Тийм	Үгүй	
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	+ Тийм	Үгүй	
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	+ Тийм	Үгүй	
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
3.Эрх агуулагч	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	+ Үгүй	
	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	+ Тийм	Үгүй	
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	+ Үгүй	шаардлагагүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	+ Үгүй	
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	+ Тийм	Үгүй	
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
		Тийм	+ Үгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	+ Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	+ Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	+ Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	+ Тийм	Үгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	+ Үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	+ Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	+ Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	+ Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	

6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	дэмжих боломжтой
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	дэмжих боломжтой
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	+ Тийм	Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	+ Тийм	Үгүй	ээрэгээр
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	+ Тийм	Үгүй	ээрэгээр
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	+ Тийм	Үгүй	
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	+ Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	+ Тийм	Үгүй	
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	+ Тийм	Үгүй	
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	+ Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	+ Тийм	Үгүй	

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	+ Тийм	Үгүй	
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	+ Тийм	Үгүй	зэрэг
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	+ Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	+ Үгүй	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	+ Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	+ Тийм	Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	+ Тийм	Үгүй	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	

5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй	
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+	Үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй	
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+	Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+	Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+	Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+	Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+	Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	+	Үгүй	

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	+ Тийм	Үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	+ Үгүй	
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	+ Тийм	Үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	+ Үгүй	
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	+ Үгүй	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	+ Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй

Нэг. "Монголын цахилгаан холбоо" ХК

"Монголын цахилгаан холбоо" ХК нь 1921 онд "Шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороо" нэрээр эмхлэгдэн байгуулагдсан, 100 жилийн түүхтэй, Монгол Улсын харилцаа холбооны салбарын ууган компани юм. Компани нь 1992 онд "Монголын Харилцаа Холбоо" компани, 1995 онд "Монголын Цахилгаан Холбоо" хувьцаат компани болон байгуулагдаж, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж байсан, Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани юм.

2018 оны 4 дүгээр сарын 19 ний өдрөөс "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн БНСУ-ын эзэмшлийн хувьцааг Монгол Улсын Засгийн Газар худалдан авснаар "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн хувьцааны 94.7 хувийг Монгол Улсын Засгийн газар эзэмшиж байна. Монголын цахилгаан холбоо ХК нь одоогоор Улаанбаатар хот түүний алслагдсан 2 дүүрэг, 21 аймаг, 290 гаруй сум сууринд үйлчилгээгээ хүргэн ажиллаж байгаа бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 513 ажилтан, албан хаагчидтай үйл ажиллагаа явуулж байна. Монгол улсын нийт нутаг дэвсгэрт цахилгаан холбоо, улс хоорондын яриа, интернэт, кабелийн телевиз, мэдээллийн лавлах үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж ажилладаг.

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо, ширхэг	Эзэмшлийн хувь	Нэрлэсэн үнэ, төгрөг	Нийт үнэ, мянган төгрөг
Төр түүнийг төлөөлж хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Монгол Улсын Засгийн газар	24,499,287	94.7%	100	2,499,928.7
Олон нийт	1,370,989	5.3%	100	137,098.9
НИЙТ	25,870,276	100.0%	100	2,587,027.6

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

д/д	Үзүүлэлт	2021 он	2022 он	2023 он	2024 он
	Төрийн өмчийн хувь	94.7%	94.7%	94.7%	94.7%
1	Авлага	3,876.5	2,379.9	5,089.4	8,446.95
2	Эргэлтийн хөрөнгийн дүн	11,567.4	9,373.6	11,643.5	15,932.75
3	Үндсэн хөрөнгийн дүн	31,426.9	39,666.5	48,662.8	48,328.6
4	Нийт хөрөнгийн дүн	42,994.3	49,040.1	60,306.3	64,427.89
5	Нийт өглөг	8,501.8	12,371.9	9,386.3	15,489.55
6	Өөрийн хөрөнгө	34,492.5	36,668.2	50,919.7	48,938.33
7	Нийт орлого	17,990.1	18,814.1	19,985.5	26,926.28
8	Нийт зардал	17,951.0	18,779.9	19,929.0	26,814.98
9	Цэвэр ашиг (алдагдал)	4.7	10.7	41.1	58.68
10	Ажиллагсдын тоо	720	690	516	513
11	Хөрөнгийн өгөөж	0.01	0.07	0.04	0.09
12	Эздийн өмчийн өгөөж	0.01	0.03	0.06	0.12

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
94.7%	48.9 тэрбум ₮	64.4 тэрбум ₮	3.2 тэрбум ₮

Хоёр. "Хөдөө аж ахуйн бирж" ХХК

Улсын Их Хурлын 2011 онд баталсан "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай" хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоол, Төрийн өмчийн хороо /хуучин нэрээр/-ны 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн 40 дүгээр тогтоолын дагуу "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийг үүсгэн байгуулсан.

"Хөдөө аж ахуйн бирж" ХХК нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн оновчтой тогтолцоо бүхий зах зээлийг бий болгон тогтвортой ажиллуулах, малчдын түүхий эд баялгийг зах зээлийн бодит үнээр дотоодын үйлдвэрлэгчдэд шууд худалдах боломжийг бүрдүүлэх зорилгоор логиستيкийн төв сүлжээ бий болгож, арилжаа, клиринг, төлбөр тооцооны олон улсын шаардлагад нийцсэн программ хангамж, технологийн шинэчлэл хийх, үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг зах зээлд нэвтрүүлж, хил дамнасан арилжааг зохион байгуулан ажиллаж байна.

Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн "Төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг тогтоох тухай" 47 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн биржийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж байна.

"Хөдөө аж ахуйн бирж" ХХК нь 2024 онд 177 удаагийн цахим арилжаа зохион байгуулан 933 хэлцлээр 1 их наяд төгрөгийн арилжаа зохион байгуулсан нь өмнөх онтой харьцуулахад арилжааны нийт үнийн дүн 17.2 хувиар өссөн байна.

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо, ширхэг	Эзэмшлийн хувь	Нэрлэсэн үнэ, төгрөг	Нийт үнэ, мянган төгрөг
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	10,217,000	100%	100	1,021,700.0
НИЙТ	10,217,000	100.0%	100	1,021,700.0

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

д/д	Үзүүлэлт	2021 он	2022 он	2023 он	2024 он
	Төрийн өмчийн хувь	100/%	100%	100%	100%
1	Авлага	2,275.8	2,129.7	2,108.3	2,190.7
2	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,263.8	3,161.2	6,617.7	2,658.3
3	Үндсэн хөрөнгийн дүн	2,007.2	3,507.2	3,265.5	1,900.0
4	Нийт хөрөнгийн дүн	7,976.2	6,668.4	9,883.2	5,819.1
5	Нийт өглөг	626.3	188.2	320.7	408.4
6	Өөрийн хөрөнгө	1,021.7	1,021.7	1,021.7	5,410.7
7	Нийт орлого	6,400.3	7,181.6	8,135.9	6,594.1
8	Нийт зардал	2,197.1	6,050.4	4,328.7	5,665.6
9	Цэвэр ашиг (алдагдал)	3,770.9	1,015.8	3,426.3	835.4
10	Ажиллагсдын тоо	43	36	36	20
11	Хөрөнгийн өгөөж	47.28	16.96	34.67	14.36
12	Эздийн өмчийн өгөөж	51.31	15.68	36.79	15.44

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
100%	5.4 тэрбум ₮	5.8 тэрбум ₮	967.1 сая ₮

Гүрав. "Үндэсний давхар даатгал" ХК

"Үндэсний давхар даатгал" ХК нь Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн дагуу Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 280 дугаар тогтоолоор "Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК нэртэйгээр байгуулагдсан ба байгалийн болзошгүй болон гэнэтийн эрсдэлээс малчид, тариаланчдыг хамгаалан олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, дотоодын даатгалын компаниудыг давхар даатган ажиллаж байна.

"Үндэсний давхар даатгал" ХК нь Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль" болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 01 сарын 21-ний өдрийн 48 тоот тогтоолоор давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан.

Монгол Улсын Засгийн газраас давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, гадаад валютын гадагш чиглэсэн урсгалыг бууруулах, дотоодын даатгагчдын санхүүгийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор 2018 оны 10 сарын 10-ны өдрийн 303 тоот тогтоолоор "Үндэсний давхар даатгал" ХК болгон үйл ажиллагааг өргөжүүлсэн.

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо, ширхэг	Эзэмшлийн хувь	Нэрлэсэн үнэ, төгрөг	Нийт үнэ, мянган төгрөг
Төр түүнийг төлөөлж хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Сангийн сайд	245,000,000	100%	100	24,500,000.00
НИЙТ	245,000,000	100%	100	24,500,000.00

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

д/д	Үзүүлэлт	2021 он	2022 он	2023 он	2024 он
	Төрийн өмчийн хувь	100%	100%	100%	100%
1	Авлага	631.02	449.67	2,802.09	0.0
2	Эргэлтийн хөрөнгийн дүн	57,031.94	59,504.91	65,446.30	60,914.6
3	Үндсэн хөрөнгийн дүн	812.58	791.87	468.91	200.0
4	Нийт хөрөнгийн дүн	57,844.52	60,296.78	65,915.21	61,121.5
5	Нийт өглөг	8,598.34	13,207.73	16,043.26	12,147.2
6	Өөрийн хөрөнгө	49,246.18	47,089.05	49,871.95	48,900.0
7	Нийт орлого	9,937.02	9,175.7	14,489.0	24,718.0
8	Нийт зардал	7,160.1	5,763.7	10,965.4	22,741.2
9	Цэвэр ашиг (алдагдал)	2,230.87	2,913.26	3,753.7	1,131.7
10	Ажиллагсдын тоо	40	53	42	56
11	Хөрөнгийн өгөөж	3.86%	5.66%	4.22%	1.85%
12	Эздийн өмчийн өгөөж	4.53%	6.19%	5.58%	2.31%

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
100%	48.9 тэрбум ₮	61.1 тэрбум ₮	1.6 тэрбум ₮

Дөрөв. “Монголын хөрөнгийн бирж” ХК

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь үнэт цаасны арилжаа эрхлэх үндсэн үйл ажиллагаа бүхий байгууллага юм. Монгол улсад хөрөнгийн зах зээл үүсэж, Монголын хөрөнгийн бирж байгуулагдсанаас хойш эдүгээ хөгжлийнхөө 30 жилийг туулан өнгөрүүлжээ.

Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдах ажлыг эрчимжүүлэх, мөн зах зээл дэх төрийн оролцоог багасгах, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэх хүрээнд Улсын Их Хурлын 2022 оны “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” 16 дугаар тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 66 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган арилжаалж, нийт 11.9 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь 2024 онд Арилжаа зохион байгуулалтын хувьд нийт 250 удаагийн үнэт цаасны арилжаагаар нийт 1 их наяд 406.12 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаас арилжлаа. Үүнээс хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа 317.52 тэрбум төгрөг, өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжаа 732.22 тэрбум төгрөг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа 61.63 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч арилжаа 10.89 тэрбум төгрөгт хүрсэн.

Мөн 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 13 их наяд 017 тэрбум төгрөг буюу түүхэн дээд түвшинд хүрсэн бол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр ТОП-20 индекс 51,296.39 нэгжид хүрсэн байна.

Мөн Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 89 тоот тогтоолоор нийслэлийн төсөвт тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор 500 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх “Улаанбаатар бонд”-ыг олон нийтэд нээлттэй санал болгосон нь Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдсан орон нутгийн анхны бонд болсон.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Нийт орлого	1,124.7	5,521.0	4,399.3	16,722.6	46,679.6
Нийт зардал	2,101.2	2,168.2	3,629.5	6,385.1	8,685.9
Цэвэр ашиг/алдагдал	-1,037.8	3,184.5	646.2	9,307.7	34,194.5
Авлага	84.1	104.9	505.5	2,019.4	3,119.5
Өглөг	2,193.4	941.1	1,989.5	883,215.1	769,778.4
Ажиллагсдын тоо	51	53	54	70	70
Хөрөнгийн өгөөж %		59.21	3.02	1.00	4.05
Эздийн өмчийн өгөөж %		71.76	2.75	21.12	46.27

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
66%	73.9 тэрбум ₮	843.7 тэрбум ₮	6.1 тэрбум ₮

Тав. “Хөдөө аж ахуйн корпораци” ХХК

“Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК нь Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 394 дугаар тогтоолоор байгуулагдсан ба 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Хөдөө аж ахуйг дэмжих сан татан буугдсан тул тус сангийн бүтэц, хүний нөөц, үйл ажиллагаа, салбар агуулах, эд хөрөнгийг бүрэн шилжүүлэн авч үйл ажиллагаагаа эхлүүлэн ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар нийт 6 салбартай, 121 ажилтан албан хаагчтай ажиллаж байна. Төв салбар 33 ажилтан албан хаагчтай ба 2024 оны 10-р сард Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулах, бүсчилсэн хөгжлийн бодлогыг дэмжих зорилгоор УИХ, ЗГ-ын шийдвэрийн дагуу Дархан-Уул аймагт шилжин суурьшаад ажиллаж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2023	2024
Нийт орлого	131,867.5	92,630.8
Нийт зардал	30,391.8	70,536.8
Цэвэр ашиг	101,475.7	22,093.9
Авлага	194,250.3	178,068.3
Өглөг	270,370.3	268,171.0
Ажиллагсдын тоо	248	132
Хөрөнгийн өгөөж /%/	29.63	6.1
Эздийн өмчийн өгөөж %	140.8	23.44

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
100%	94.2 тэрбум ₮	362.4 тэрбум ₮	2.8 тэрбум ₮

Зургаа. “МИАТ” ТӨХК

“МИАТ” ТӨХК нь 1956 онд үүсгэн байгуулагдаж, 1993 оноос хойш Монгол Улсын Үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК нэрээр тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй ууган агаарын тээвэрлэгч компани юм. Компани нийт 10 агаарын хөлөг, 1078 ажилтантайгаар Ази болон Европын чиглэлд зорчигч, ачаа тээврийн нислэг үйлдэж, дотоодын болон гадаадын агаарын хөлөгт агаарын хөлгийн засвар, техник үйлчилгээг олон улсын 11, орон нутгийн 9 чиглэлд нислэг үйлдэн ажиллаж байна.

Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан аялал жуулчлалын орох, гарах урсгал болон нислэг тээвэрлэлтээ нэмэгдүүлэх, тийзийн урамшуулалт хөтөлбөрүүд зарлах, олон улсын хуваарьт нислэгийн тийзийн үндсэн тарифыг бууруулах, агаарын хөлгийн паркийг шинэчлэх зэрэг менежментийг оновчтой хийж, 2024 онд 1 сая зорчигч, 14 мянган тонн ачаа тээвэрлэхээр зорилт тавин ажиллаж, 1,153.1 мянган зорчигч, 12.6 мянган тонн ачаа тээвэрлээд байна.

Компанийн хувьцааг мөнгөн урсгалд суурилсан үнэлгээ /Free Cash Flow to Equity/ болон зах зээлийн харьцуулсан үнэлгээ /Relative Valuation/ гэсэн 2 үнэлгээний аргыг ашиглан, урьдчилсан үнэлгээ хийж үзсэн.

Мөнгөн урсгалд суурилсан үнэлгээнд компанийн 2023-2027 оны мөнгөн урсгалыг тооцоолж, капиталын өгөөж болох 35%-аар хорогдуулж, нийт 111.5 сая ширхэг хувьцаанд хувааснаар нэгж хувьцааны үнэ 2,025 төгрөгөөр үнэлэгдсэн. Зах зээлийн харьцуулсан үнэлгээний аргын дагуу олон улсад нээлттэй хувьцаат компаниудаас өндөр өр, эздийн өмчийн харьцаатай, бага зах зээлийн хэмжээтэй, бага орлоготой байх гэсэн шалгууруудыг тавьж 34 компанийг сонгон EV/EBITDA харьцааг ашиглаж, нэгж хувьцааг 3,325 төгрөгөөр үнэлсэн. Дээрх 2 арга нь компанийн хувьцааг үнэлэхэд тохиромжтой аргууд тул тус бүр 50%, 50%-аар жинлэж "МИАТ" ТӨХК-ийн нэгж хувьцааг 2,678 төгрөгөөр үнэлж олон нийтэд санал болгох тооцооллыг хийсэн.

Хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд, хөрөнгө оруулалтын хамтын сан болон үнэт цаасны компаниуд зэрэг мэргэжлийн буюу стратегийн хөрөнгө оруулагчид нэмэгдсэн тул стратегийн хөрөнгө оруулагчдад хувьцааны өндөр хувийг санал болгосноор компанийн засаглал, менежментийг дээшлүүлэх, цаашлаад компанийн үйл ажиллагаанд эергээр нөлөөлж, илүү үр ашигтай ажиллах боломжийг бүрдүүлэх юм.

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо, ширхэг	Эзэмшлийн хувь	Нэрлэсэн үнэ, төгрөг	Нийт үнэ, мянган төгрөг
Төр түүнийг төлөөлж хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Монгол Улсын Засгийн газар	55,772,830	100%	100	5,577,283,000
НИЙТ	55,772,830	100.0%	100	5,577,283,000

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

д/д	Үзүүлэлт	2021 он	2022 он	2023 он	2024 он
	Төрийн өмчийн хувь	100%	100%	100%	100%
1	Авлага	17,145.8	32,121.2	59,271.4	77,883.4
2	Эргэлтийн хөрөнгийн дүн	80,468.0	125,412.0	183,284.0	198,261.6
3	Үндсэн хөрөнгийн дүн	118,421.0	104,576.0	103,029.0	265,900.0
4	Нийт хөрөнгийн дүн	428,919.0	504,490.0	722,321.0	1,056,233.0
5	Нийт өглөг	398,906.0	429,399.0	588,393.0	771,058.4
6	Өөрийн хөрөнгө	30,012.0	75,091.0	133,928.0	285,200.0
7	Нийт орлого	234,451.0	490,407.0	832,988.0	948,795.6
8	Нийт зардал	245,905.0	447,806.0	766,810.0	925,761.8
9	Цэвэр ашиг (алдагдал)	(11,510.0)	36,987.0	51,915.0	12,482.8
10	Ажиллагсдын тоо	802	798	909	1078
11	Хөрөнгийн өгөөж	-2.7%	7.3%	7.2%	1.18%
12	Эздийн өмчийн өгөөж	-38.4%	49.3%	38.8%	4.38%

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
100%	285.2 тэрбум ₮	1,056 тэрбум ₮	37.4 тэрбум ₮

Долоо. “Төрийн банк” ХК

Төрийн Банк нь олон улсын стандартад нийцсэн орчин үеийн банк, санхүүгийн цогц үйлчилгээг орон даяар саадгүй хүргэх, бүх талын хамтын ажиллагааг дээдлэх, харилцагчдынхаа бизнесийн үйл ажиллагааг тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлэх, санхүүгийн олон талт хэрэгцээг хангахад чиглэн, Монгол орон даяар 500 гаруй салбар нэгж, 350 АТМ, 8,698 гаруй картаар үйлчлэгч байгууллагаар дамжуулан үндэсний хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 56 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 34 дүгээр тэмдэглэл, Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн хамтарсан 2022 оны 30/А191 дүгээр тушаалаар баталсан “Төрийн банк”-ийг олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд “Төрийн банк” ХК-ийн нийт хувьцааны 5% буюу 34,745,000 ширхэг хувьцааг нэгж хувьцааны үнэ 590 төгрөгөөр тооцон 22.1 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр тооцсон. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болж, 5.71 хувийн хувьцааг 7306 хувь хүн, аж ахуйн нэгж санал ирүүлж, 25.4 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн болно.

№	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Хувьцааны тоо	Мөнгөн дүнгээр /төгрөг/	Эзлэх хувиар
1	Сангийн яам	372,000,000.00	93,000,000,000.00	49.26%
2	Хадгаламжийн даатгалын корпораци	340,000,000.00	85,000,000,000.00	45.03%
3	Олон нийт	43,096,250.00	10,774,062,500.00	5.71%
Нийт		755,096,250.00	188,774,062,500.00	100.00%

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Нийт орлого	406,743.7	419,390.4	459,587.8	557,795.8	745,911.8
Нийт зардал	376,131.8	358,375.6	335,334.2	434,207.9	606,191.9
Цэвэр ашиг	30,611.9	45,747.6	97,294.8	94,769.1	107,966.0
Авлага	14,058.3	646.6	8,016.3	2,247,181.8	3,396,732.1
Өглөг	13,160.3	3,404,250.3	3,668,432.4	4,792,920.9	5,589,744.2
Ажиллагсдын тоо	3,954	3,996	3,856	3,994	3,376
Хөрөнгийн өгөөж %		1.21	2.98	1.77	1.73
Эздийн өмчийн өгөөж %		11.78	19.61	16.47	17.03

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
94.29%	634.1 тэрбум ₮	6,224.0 тэрбум ₮	106.0 тэрбум ₮

Найм. “Эрдэнэс таван толгой” ХК

“Эрдэнэс таван толгой” ХК нь Монгол Улсын Их Хурлын “Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” 2010 оны 39 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолоор байгуулагдаж, Таван толгой нүүрсний ордод ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагааг 2010 оноос эхлэн явуулж байна. Тус компани нь Таван толгойн орд газарт 8 тусгай зөвшөөрөл эзэмшдэг 9 газар, 21 хэлтэс, 2 алба, 1 салбар нийт 1120 ажилтан, албан хаагчидтай. Тус компанийн нийт хувьцааны 73.51%-ийг Монгол Улсын төр, 26.34%-ийг Монгол Улсын 3.4 сая иргэд, 0.06%-ийг үндэсний аж ахуйн нэгжүүд тус тус эзэмшиж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Нийт орлого	1,578,118.1	1,165,726.0	3,681,597.9	9,683,145.4	10,563,779.4
Нийт зардал	1,333,091.5	1,001,410.4	2,086,364.5	4,934,836.0	4,541,948.0
Цэвэр ашиг	149,018.6	110,761.0	1,110,525.5	3,527,725.9	4,522,618.0
Авлага	34,210.4	22,416.1	679,276.8	633,569.8	970,261.3
Өглөг	2,040,853.7	3,060,899.4	4,317,310.5	3,812,434.9	6,633,703.6
Ажиллагсдын тоо			4,504	5,243	4,603
Хөрөнгийн өгөөж %		0.72	8.50	16.88	18.81
Эздийн өмчийн өгөөж %		0.90	7.68	20.65	25.98

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
73.51%	17,409 тэрбум ₮	24,042 тэрбум ₮	3,499 тэрбум ₮

Ес. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь зэс, молибдены хүдрийн олборлолт, баяжуулалтаар Азид тивдээ томоохонд тооцогддог үйлдвэр бөгөөд жилд 36 сая тонн хүдэр олборлон, 33 сая тонн хүдэр боловсруулж, 580.0 орчим мянган тонн зэсийн баяжмал, 6.0 орчим мянган тонн молибдены баяжмал үйлдвэрлэдэг.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Нийт орлого	2,203,804.4	3,130,390.9	3,741,009.5	4,035,384.5	3,974,627.4
Нийт зардал	1,774,349.9	1,893,083.1	2,566,665.7	2,926,243.3	3,150,206.7
Цэвэр ашиг	263,100.5	901,547.5	831,164.1	803,034.2	578,528.5
Авлага	208,555.4	156,828.3	34,244.5	49,930.2	18,845.6
Өглөг	415,664.0	990,461.3	1,034,052.9	1,047,685.2	1,252,761.3

Ажиллагсдын тоо	6,586	6,695	6,850	6,895	6,910
Хөрөнгийн өгөөж %		15.62	20.00	12.86	8.67
Эздийн өмчийн өгөөж %		18.85	17.18	15.46	10.68

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
100.0%	5,418.4 тэрбум ₮	6,671.1 тэрбум ₮	1,276.1 тэрбум ₮

Арав. "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь дэлхийн жонш үйлдвэрлэлийн 4 хувь, Монголын жоншны экспортын 50 хувийг үйлдвэрлэдэг бөгөөд дэлхийн хайлуур жоншны зах зээлд хүлээн зөвшөөрөгдсөн 3 төрлийн баяжмалаас гадна 52% болон 65%-ийн агуулгатай төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэн экспортолж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Нийт орлого	226,408.7	257,961.4	98,703.8	221,386.3	311,952.2
Нийт зардал	151,215.2	141,313.3	88,874.6	185,365.6	275,043.7
Цэвэр ашиг	48,211.7	85,804.7	1,333.4	25,462.5	25,717.7
Авлага	5,643.7	29,655.2	2,324.4	14,968.6	25,146.9
Өглөг	46,137.2	71,061.2	163,686.1	263,221.9	278,373.7
Ажиллагсдын тоо	1,503	1,552	1,640	1,653	1,634
Хөрөнгийн өгөөж %		30.22	2.87	5.45	5.20
Эздийн өмчийн өгөөж %		40.31	0.75	12.50	11.87

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
100.0%	216.6 тэрбум ₮	494.9 тэрбум ₮	62.9 тэрбум ₮

Арван нэг. "Дулааны III цахилгаан станц" ТӨХК

Тус станц өндөр ба дунд даралтын гэсэн 2 хэсгээс бүрддэг бөгөөд дунд даралтын станц 48 меговатт, Өндөр даралтын станц 150 меговатт нийт 198 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтай. Бүтэц зохион байгуулалтын хувьд 3 алба, 7 хэлтэс, 4 хэсэг, 2 лаборатори, 10 цехээс бүрдсэн нийт 1000 гаруй ажиллагсадтайгаар цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагаа явуулж байна.

Компани 2025 оны эхний хагас жилд цахилгаан цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 99.2 хувиар, түгээлтийн төлөвлөгөөг 99.4 хувиар, дулааны

эрчим хүчний түгээлтийн төлөвлөгөөг 100.4 хувиар, диспетчерийн графикийг цахилгаанд 100.3 хувиар, дулаанд 100.0 хувиар биелүүлсэн байна.

Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчийг 1.1 сая кВт.ц буюу 0.08 пунктээр, жишмэл түлшний хувийн зарцуулалтыг цахилгаанд 4.4 гр/кВт.ц-аар, дулаанд 0.2 кг/Гкал-аар тус тус бууруулан ажилласан.

2025 оны эхний хагас жилд үндсэн үйл ажиллагаанаас 5,930.1 сая төгрөгийн, үндсэн бус үйл ажиллагаанаас 1,834.3 сая төгрөгийн, нийт татвар төлөхийн өмнөх байдлаар 7,764.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж төлөвлөгөөт алдагдлыг 2,808.6 сая төгрөгөөр, борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардлыг 3 мөнгөөр тус тус бууруулсан байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
ЦЭХ үйлдвэрлэл /сая кВт.ц/	1,050.1	1,109.2	1,085.8	1,132.3	1,115.0
Түгээсэн дулаан /мян.Гкал/	2,369.3	2,466.9	2,605.7	2,527.9	2,579.5
Нийт орлого	122,738.5	128,984.8	132,192.1	163,483.9	187,521.9
Нийт зардал	124,807.9	128,960.2	138,673.0	164,592.3	186,543.8
Цэвэр ашиг/алдагдал/	-2,107.6	24.0	-6,480.9	-1,130.6	875.8
Авлага	9,713.8	16,479.8	11,236.4	7,739.0	5,924.0
Өглөг	30,494.2	30,403.2	26,650.0	18,858.1	29,848.5
Ажиллагсдын тоо	995	996	986	1001	1001
Хөрөнгийн өгөөж %		0.01	-2.25	-0.4	0.3
Эздийн өмчийн өгөөж %		0.01	-2.48	-0.43	0.33

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
100%	353.5 тэрбум ₮	385.2 тэрбум ₮	17.2 тэрбум ₮

Арван хоёр. "Дулааны IV цахилгаан станц" ТӨХК

2001 оны 8 дугаар сараас Компанийн тухай хуулиар Төрийн өмчит хувьцаат компани болж үйл ажиллагаагаа явуулж байна. Тус компани нь нэгдсэн системийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний 58.3 хувийг, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний хэрэглээний 55.6 хувийг дангаараа үйлдвэрлэн хэрэглэгчдийн хэрэгцээ, тав тухтай байдлыг ханган ажиллаж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
ЦЭХ үйлдвэрлэл /сая кВт.ц/	4,110.3	4,538.7	4,736.6	4,871.4	4,985.9
Түгээсэн ЦЭХ /сая кВт.ц/	482.5	509.8	4,111.5	4,329.5	4,436.1
Түгээсэн дулаан /мян.Гкал/	4,029.5	4,172.1	4,551.4	4,636.9	4,733.8
Нийт орлого	295,923.3	348,216.5	331,435.7	436,301.5	508,086.5
Нийт зардал	330,203.9	329,202.0	381,490.5	430,624.4	507,769.5

Цэвэр ашиг/алдагдал	-35,487.8	17,829.8	-50,409.6	1,161.9	-1,556.8
Авлага	17,858.8	31,804.1	19,604.3	22,049.0	35,300.9
Өглөг	590,395.5	470,238.3	484,245.0	466,702.2	453,454.8
Ажиллагсдын тоо	1489	1,480	1,487	1,487	1,486
Хөрөнгийн өгөөж %		1.70	(4.95)	0.12	(0.16)
Эздийн өмчийн өгөөж %		3.07	(9.57)	0.22	(0.30)

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
100%	526.9 тэрбум ₮	980.4 тэрбум ₮	53.9 тэрбум ₮

Арван гурав. "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолоор тус станцыг "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" нэртэйгээр төрийн өмчит хувьцаат компани болгон зохион байгуулсан. Станцын эхний ээлж 1987 оноос ашиглалтад орж цахилгаан, дулаан үйлдвэрлэж эхэлснээс хойш 30 дахь жилдээ Эрдэнэт хотын ард иргэдийг дулаан, цахилгааны эрчим хүчээр тасралтгүй, найдвартай ханган ажиллаж байна. Эрдэнэтийн Дулааны Цахилгаан Станц нь 7 зуух, 3 турбинтэй, цагт 302.5 Гкал/цаг дулаан, 28,8 МВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
ЦЭХ үйлдвэрлэл /сая кВт.ц/	158.8	271.0	427.1	440.0	432.1
Нийт орлого	42,737.5	50,028.9	62,860.3	84,879.9	90,640.1
Нийт зардал	42,144.1	49,968.4	66,192.2	81,382.9	90,326.7
Цэвэр ашиг/алдагдал	543.4	54.1	-3,661.6	3,003.9	266.4
Авлага	3,584.3	5,709.5	3,600.0	4,368.2	5,604.6
Өглөг	6,493.7	6,819.7	13,661.7	9,586.4	16,340.2
Ажиллагсдын тоо	450	450	461	450	465
Хөрөнгийн өгөөж %		0.06	(3.43)	3.04	0.26
Эздийн өмчийн өгөөж %		0.06	(4.39)	3.47	0.31

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
100%	86.7 тэрбум ₮	103.1 тэрбум ₮	12.1 тэрбум ₮

Арван дөрөв. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК

"Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компани нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах 9 тусгай зөвшөөрлийн хүрээнд Дорнод, Сүхбаатар аймгийн 36 сум, багийн 27679 айл өрх, 2373 аж ахуйн нэгж, албан байгууллага, уул уурхайн 17 ордын баяжуулах, олборлох үйлдвэрийг 0.4, 10, 15, 35, 110 кВ-ын 3375,83 км агаарын ба кабель шугам, 468 ком дэд станцыг ашиглан цахилгаан эрчим хүчээр, Чойбалсан хотын 742 аж ахуйн нэгж, 94 төсвийн байгууллага, 6481 орон сууцны хэрэглэгчдийг 17.6 хос/км шугамаар дамжуулан дулааны эрчим хүчээр хангаж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
ЦЭХ үйлдвэрлэл /сая.квт.ц/	234.0	245.6	242.7	248.8	297.1
Нийт орлого	47,266.1	51,828.2	51,470.5	68,624.9	85,954.0
Нийт зардал	46,943.6	51,093.7	56,941.2	63,233.8	87,710.0
Цэвэр ашиг/алдагдал	302.4	688.4	-5,470.7	4,879.1	-1,892.4
Авлага	1,113.1	2,822.5	2,782.5	3,043.7	3,005.6
Өглөг	16,402.1	40,756.5	66,082.0	170,202.1	296,280.7
Ажиллагсдын тоо	620	620	620	620	710
Хөрөнгийн өгөөж %		0.55	(3.79)	1.93	(0.5)
Эздийн өмчийн өгөөж %		0.82	(7.00)	5.88	(2.35)

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
100%	80.5 тэрбум ₮	376.7 тэрбум ₮	12.3 тэрбум ₮

Арван тав. "Дарханы дулааны цахилгаан станц" ТӨХК

"ДДЦС" ТӨХК нь 9 зуух, 4 турбогенератортой. Суурилагдсан хүчин чадал 48 МВт/цаг. Дархан, Сэлэнгийг цахилгаан эрчим хүчээр, Дархан хотыг дулааны эрчим хүчээр хангадаг бөгөөд жилдээ 302,8 сая кВт/цаг цахилгаан эрчим хүч, 1196 мянган Гкал дулааны эрчим хүч боловсруулах чадалтай.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
ЦЭХ үйлдвэрлэл /сая кВт.ц/	346.8	332.2	413.9	427.3	434.2
Нийт орлого	55,563.6	62,069.7	64,249.5	81,305.7	87,586.2
Нийт зардал	67,174.7	59,697.1	72,498.9	85,911.7	83,646.7

Цэвэр ашиг/алдагдал	-11,611.1	2,372.6	-8,249.4	-4,607.3	3,939.3
Авлага	4,444.8	6,727.8	4,020.9	4,008.8	4,303.3
Өглөг	95,752.4	90,082.8	90,917.3	87,765.0	82,262.8
Ажиллагсдын тоо	485	485	484	452	475
Хөрөнгийн өгөөж %		1.31	(4.75)	(2.76)	2.35
Эздийн өмчийн өгөөж %		2.59	(9.97)	(5.82)	4.6

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
100%	85.6 тэрбум ₮	167.9 тэрбум ₮	16.4 тэрбум ₮

Арван зургаа. "Амгалан дулааны станц" ТӨХК

"Амгалан дулааны станц" ТӨХК нь 348 Мвт-ийн суурилагдсан хүчин чадалтай, эргэлтэт буцлах давхаргат шаталт бүхий QXF116-1.6/130/70 маркийн 3 зуухтай, цагт дунджаар 4800 тн усыг 120° хүртэл халаадаг, жилд дунджаар 626.5 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэдэг, зуухнаас гарсан утааны хийнээс үнс, тоосонцорыг 99% шүүдэг үнсний уутат шүүлтүүртэй, нүүрсийг нар, салхи борооноос хамгаалсан 20000 м куб эзэлхүүнтэй нүүрсний агуулахтай. Тус станц нь 181 ажилтантай 3 цех, 4 хэлтэстэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
ДЭХ үйлдвэрлэл/мян.Гкал/	761.6	739.5	841.8	1,037.3	1,041.1
Нийт орлого	21,012.0	21,197.2	24,219.9	67,837.9	63,224.6
Нийт зардал	28,407.5	28,747.5	32,779.1	45,449.3	51,956.3
Цэвэр ашиг/алдагдал	-7,696.2	-7,906.2	-8,802.5	20,388.7	9,865.4
Авлага	925.2	843.8	895.8	5,488.3	475.8
Өглөг	4,590.8	5,499.5	9,544.4	49,522.2	33,378.9
Ажиллагсдын тоо	186	186	186	186	186
Хөрөнгийн өгөөж %		(8.99)	(10.29)	14.34	7.17
Эздийн өмчийн өгөөж %		(9.59)	(11.96)	21.87	9.47

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
100%	104.2 тэрбум ₮	137.5 тэрбум ₮	10.5 тэрбум ₮

Арван долоо. "Дулаан шарын гол" ТӨХК

Шарын гол сумын 1134 айл өрх, 128 аж ахуй нэгж, 14 төсвийн байгууллагыг дулааны эрчим хүч, хэрэгцээний халуун, хүйтэн усаар хангах тэдгээрийн бохир усыг татан зайлуулахаар 7,5 км хос дулааны шугам, 17 км цэвэр усны шугам, 12 км бохир усны шугам, 19,6 мВт дулааны эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай DZL маркийн 4 зуухтай, гэр хорооллын айл өрхүүдэд зөөврийн усаар хангах 4 ус түгээх байр, 24 цагийн ажиллагаатай 2 ухаалаг ус түгээх байртай.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
ДЭХ үйлдвэрлэл /мян.Гкал/	38.8	38.8	38.2	40.9	45.4
Нийт орлого	3,041.6	3,032.1	3,590.4	4,327.4	4,798.8
Нийт зардал	3,499.3	3,216.8	3,637.4	4,172.7	4,809.8
Цэвэр ашиг/алдагдал	-457.8	-184.7	-47.1	139.0	-11.0
Авлага	329.5	433.7	223.8	220.1	81.5
Өглөг	1,812.1	1,838.8	1,344.4	992.1	648.3
Ажиллагсдын тоо	111	98	95	86	96
Хөрөнгийн өгөөж %		(2.59)	(0.70)	2.13	(0.18)
Эздийн өмчийн өгөөж %		(3.50)	(0.88)	2.51	(0.2)

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
100%	5.5 тэрбум ₮	6.1 тэрбум ₮	1.097 тэрбум ₮

Арван найм. "Цемент шохой" ТӨХК

Хөтөлийн цемент, шохойн комбинатыг ББМҮЯ-ны сайдын 1983 оны 127 дугаар тоот тушаалаар цементийн үйлдвэр, шохойн үйлдвэр, уулын олборлох үйлдвэр, засвар механикийн контор, дулааны станц гэсэн бүтэцтэй анх байгуулагдсан. 1986 онд цементийн үйлдвэрийн технологийн 1, 2 дугаар шугамыг Улсын комисс хүлээн авснаар цементийн үйлдвэрлэл эхэлсэн. "Цемент шохой" ХХК нь барилга, авто зам болон бусад салбар (баяжуулах үйлдвэр гэх мэт)-ыг түүхий эдээр ханган нийлүүлэх зорилгоор цемент болон шохойн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он
Нийт орлого	83,157.9	86,268.3	72,313.5

Нийт зардал	68,540.8	73,262.3	72,266.2
Цэвэр ашиг	11,630.7	11,255.2	19.8
Авлага	11,061.0	19,669.3	20,255.1
Өглөг	360,071.9	375,935.9	389,247.6
Ажиллагсдын тоо	828	765	752
Хөрөнгийн өгөөж /%/	5.25	3.66	0.01

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
100%	-78.6 тэрбум ₮	310.6 тэрбум ₮	8.7 тэрбум ₮

Арван ёс. "Монгол шуудан" ХК

“Монгол шуудан” ХК нь 2016 онд Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан компанийн нийт хувьцааны 34%-ийг олон нийтэд хувьчилснаар нээлттэй хувьцаат компани болсон. Одоогоор Улаанбаатар хот түүний алслагдсан 2 дүүрэг, 21 аймаг, 330 гаруй сум, сууринд шуудангийн үйлчилгээгээ хүргэн ажиллаж байгаа бөгөөд нийт 950 гаруй ажилтан, албан хаагчидтай.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Нийт орлого	18,231.9	20,932.8	20,391.5	25,397.7	24,395.5
Нийт зардал	17,602.0	20,461.2	19,782.2	23,289.9	24,226.9
Цэвэр ашиг/алдагдал	557.9	400.0	451.3	1,967.7	136.0
Авлага	2,589.8	1,777.4	6,260.7	2,946.7	5,845.9
Өглөг	13,389.8	7,315.0	18,519.8	12,229.7	11,404.9
Ажиллагсдын тоо	987	997	1,009	956	961
Хөрөнгийн өгөөж %		1.25	1.40	5.13	0.37
Эздийн өмчийн өгөөж %		1.61	1.81	7.53	0.53

Төрийн эзэмшлийн хувь:	Эздийн өмчийн дүн:	Нийт хөрөнгө:	Төсвийн төлбөрт:
66%	25.6 тэрбум ₮	37.0 тэрбум ₮	4.4 тэрбум ₮

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

1. Нийтлэг зорилго

Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулах, төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангах зорилготой.

Хүснэгт 1

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	+ Үгүй	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	+ Тийм	Үгүй	
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	+ Тийм	Үгүй	
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	+ Тийм	Үгүй	
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	+ Тийм	Үгүй	
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	+ Тийм	Үгүй	
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	+ Үгүй	
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	+ Тийм	Үгүй	
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	+ Үгүй	шаардлагагүй

	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	+ Үгүй	
4.Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	+ Тийм	Үгүй	
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй

Хүснэгт 2

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
		Тийм	+ Үгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	+ Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	+ Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	+ Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	+ Тийм	Үгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	+ Үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	+ Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	+ Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	+ Үгүй	

	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	дэмжих боломжтой
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	дэмжих боломжтой
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	+ Тийм	Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	+ Тийм	Үгүй	ээрэгээр
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	+ Тийм	Үгүй	ээрэгээр
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	+ Тийм	Үгүй	
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	+ Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	+ Тийм	Үгүй	
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	+ Тийм	Үгүй	
	10.3. Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	+ Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	+ Тийм	Үгүй	

Хүснэгт 3

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	+ Тийм	Үгүй	
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	+ Тийм	Үгүй	ээрэг
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	

	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	+ Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	+ Үгүй	
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	+ Үгүй	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	+ Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	+ Тийм	Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	+ Тийм	Үгүй	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	+ Тийм	Үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	+ Үгүй	
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	+ Тийм	Үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	+ Үгүй	
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	+ Үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	+ Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	+ Үгүй	
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	+ Үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	+ Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Хамааралгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

1. Нийтлэг зорилго

Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулах, төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангах зорилготой.

Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэлийн төслийг баталсан тохиолдолд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

Тус аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг:

1. Хуулийн этгээдийн зардал

2. Иргэний үүсэх зардал

3. Төрийн байгууллагын зардал гэсэн 3 төрлөөр зардлыг тооцдог боловч үндсэн чиглэлд иргэнээс уг тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал гарахгүй гэж үзсэн.

Энэхүү тооцооллын хүрээнд хуулийн этгээд болон төрийн байгууллагаас Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой зардлууд гарахаар байна.

1. Төрийн байгууллагад үүсэх зардлын үндсэн бүлгүүд

№	Зардлын ангилал	төсөв (мянган ₮)	Хугацаа	Тайлбар
1	Бэлтгэл судалгаа, сурталчилгаа, үнэлгээ	5,200.0	2025–2026	Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн төсөл бэлтгэх
2	Хөрөнгийн биржийн бүртгэл, үнэт цаасны зуучлал, товхимол, гарын авлага	3,375.0	2026–2028	IPO гаргах, хуулийн зөвлөгөө, үнэлгээ, арилжааны шимтгэл
3	Сургалт, чадавх бэхжүүлэлт /Хотод/	10,000.0	2026–2028	Төрийн өмчит компанийн удирдлага, ажилтнуудад зориулсан сургалт,

				хөрөнгийн зах зээлийн ойлголт
4	Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах /Орон нутагт/	29,000.0	2026–2028	IPO, хувьчлалын талаарх сургалт, нээлттэй мэдээллийн зардал
5	УИХ-ын тогтоолын үндсэн чиглэлийн төсөл, үзэл баримтлал боловсруулах	20,000.0	2026–2027	Төрийн өмчийн бодлого, журмын шинэчлэл, зөвлөх үйлчилгээ
6	Бичиг хэрэг	550.0	2026-2027	
Нийт дүн:		68,125.0 (Жаран найман сая нэг зуун хорин таван мянган төгрөг)		

2. Хэрэгжилтийн үе шат

Компани анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгох буюу өөрөөр хэлбэл 100 хувь төрийн өмчтэй, эсвэл цөөн тооны хөрөнгө оруулагчидтай компани өөрийн хувьцааг олон нийтэд нээлттэй санал болгож худалдах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд үнэт цаас гаргах процесс нь нэлээд хугацаа шаардах бөгөөд, хэд хэдэн үе шат бүхий ажлыг хийж гүйцэтгэхэд хугацаа шаардагдана.

№	Үе шат	Гол ажил	Хугацаа
1	Бэлтгэл үе шат	Үнэт цаас гаргах шийдвэр гаргана: Андеррайтертай гэрээ байгуулна: Андеррайтер үнэт цаасны бүрдүүлбэр материалын жагсаалт: Аудитын болон Хуулийн дүгнэлт: Бизнесийн болон хөрөнгийн үнэлгээний тайлан, дүгнэлт:	2-3 сар
2	Баримт бичиг цуглуулах, судлах үе шат	Ирүүлсэн материал, хараат бус дүгнэлтүүдийг судлах: Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн, хувьцааны үнэ, тоо ширхэг, арилжаалах арга, түүнийг зөвшилцөн тогтоох: Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр:	1-4 сар
3	Баримт бичиг боловсруулах үе шат	Үнэт цаасны бүрдүүлбэр, танилцуулга /prospectus/ бэлтгэх:	1-2 сар
4	Үнэт цаасны бүртгэл, зөвшөөрөл, арилжаа	Монголын хөрөнгийн биржид бүртгэх шийдвэр: Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөл: Танилцуулга-road show: Анхдагч зах зээлийн арилжаа: Хоёрдогч зах зээлийн арилжаа:	1-6 сар

3. Санхүүжилтийн эх үүсвэр

Олон нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх хуулийн этгээдийн зах зээлийн үнэлгээг нарийвчлан тогтоосны үндсэн дээр хэрэгжүүлэх бөгөөд үнэлгээний зардлыг тухайн хуулийн этгээд санхүүжүүлнэ.

№	Зардлын ангилал	төсөв (сая ₮)	Хугацаа	Тайлбар
1	Аудитын компанийн хөлс	9x100=900.0		/Ажлын хэмжээнээс хамаарна/
2	Хуулийн компанийн ажлын хөлс	9x100=900.0		/Ажлын хэмжээнээс хамаарна/
3	Үнэлгээний компанийн ажлын хөлс	9x100=900.0		/Ажлын хэмжээнээс хамаарна/
4	Андеррайтерийн компанийн ажлын хөлс	-		/нийт 2,326.0 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр тооцсон түүний 5-10%/
5 6	СЗХ-ны зохицуулалтын үйлчилгээний төлбөр	0.6		Зохицуулалтын үйлчилгээний төлбөр Улсын тэмдэгтийн хураамж
7	МХБ-ийн өргөдөл, бүртгэлийн хураамж	2.6		Өргөдлийн хөлс, бүртгэлийн хураамж
8	ҮЦТХТ-ийн бүртгэлийн хураамж	1.6		Шинээр үнэт цаас бүртгэх болон хадгаламжийн хөлс
9	Анхдагч зах зээлийн арилжааны шимтгэл	-		
	Нийт зардал	2,704.8		Нэг хуулийн этгээд дундажаар 300.0 сая төгрөгийн зардал гаргана.

- Тухайн төрийн өмчит компанийн өөрийн хөрөнгө

4. Хүлээгдэж буй үр дүн

Үндсэн чиглэлд туссан 26 төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг биржээр худалдсанаар төрийн өмчит компаниудад олон нийтийн хяналтад бий болж, улс орны эдийн засагт олон нийтийн болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр компанийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, орлого олох үндсэн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах төсөл арга хэмжээнд зарцуулах, компанийн

засаглал сайжирч, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, төр болон хувийн хэвшлийн түншлэлийн зохистой хэлбэрийг бий болгоно.

Үндсэн чиглэлийн хүрээнд хөрөнгийн зах зээлд **2,326.0 тэрбум** төгрөг татан төвлөрүүлнэ.

_____ооо_____

**ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХУВЬЦААГ 2026-2028 ОНД
БИРЖЭЭР ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХУДАЛДАХ, ТӨРИЙН ӨМЧИЙГ
ХУВЬЧЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛД ИРГЭД,
ОЛОН НИЙТЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТАЛААР.**

Нэг. Цахимаар авсан санал: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын <https://pcsp.gov.mn/?p=7964> сайтаар иргэд олон нийтээс Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэлийн төсөлд санал авч нийт 24 иргэн саналаа ирүүлсэн байна. Үүнд:

1. Үндсэн чиглэлд ороогүй бусад хуулийн этгээдүүдээс нэмэх боломжтой юу. Өмнөх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд үнэлэлт өгсөн үү. “МИАТ”, Эрдэнэс таван толгой зэрэг компаниудыг оруулж ирсэн байна. дэмжиж байна. Цаашид Эрдэнэт, Эрдэнэс монгол, Багануур, ТЭЦ-4 зэрэг компаниудыг нээлттэй компани болгох хэрэгтэй гэж үзэж байна.

2. Төр хувийн хэвшлийн өрсөлдөөнийг байхгүй болгомоор байна. Төрийн банкны төрийн мэдлийн хувьцааг зараад хувьд нь шилжүүлээд явчихмаар байна.

3. Орон сууцжуулалтын банк бол ёстой худлаа, хэрэггүй төсөл шүү. “Төрийн орон сууцны корпорац” ТОСК яаралтай хурдан татан буулгах шаардлагатай төсөл болчхоод байна. 5 аймаг 4 дүүрэгт байгаа байр түрээслэгчдээс орж ирж байгаа орлогоор цалинжаад төрөөс бусад зардлаа гаргуулаад явж байгаа дээд зэргийн алдагдалтай төсөл.

4. Төрийн банкиг хувьчлах хэрэгтэй гэсэн санал ирүүлсэн байна

5. Бусад 20 иргэнээс Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэлийн төсөлд дэмжсэн санал ирүүлсэн байна.

Хоёр. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим:
/2025.11.13 02/1065 /

МҮХАҮТ-аас эдийн засаг дах төрийн оролцоог бууруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн засаглал менежментийг сайжруулах, бүтээмжийг өсгөх, үр ашиг өгөөжийг нэмэгдүүлэх талаар тодорхой тоо баримтад үндэслэсэн саналыг үе үеийн Засгийн газарт тавьж ирсэн билээ. Иймээс Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэлийг батлуулахаар ажиллаж байгаа зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Тогтоолын төсөлд 2001-2022 оны хугацаанд УИХ-аас нийтдээ төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, хувьцааг нээлттэй худалдах чиглэлээр нийт 5 удаагийн тогтоолд үнэлэлт дүгнэлт өгөх талаар тусгасан байна. Олон жилийн хугацаанд хэд хэдэн удаа үндсэн чиглэл гаргаад хэрэгжихгүй, хэрэгжилт хангалтгүй байгаад тодорхой шалтгаан, нөхцөл байдал байгаа гэж үзэж байна. Иймд тогтоолын төслөөр үнэлэлт, дүгнэлт хийхээр оруулах биш харин үнэлэлт дүгнэлт хийж, ерөнхий дүгнэлтээ танилцуулга хэсэгтээ оруулах, дүгнэлт дээрээ тулгуурлан цаашдаа авах арга хэмжээнүүдийг тодорхойлон тогтоолын төсөлд тусгах.

2. Үндсэн чиглэлийн 1) Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, 2) Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, үр ашгийг

нэмэгдүүлэх. 3) Хувьчлалыг үе шаттай үр дүнтэй явуулах. 4) Төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангах гэсэн дөрвөн зорилтыг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлох.

3. Тогтоолын төслийн дийлэнх хэсгийг төрийн өмчит компаниудын танилцуулга, өмч хувьчлалын өмнөх үе шатуудын танилцуулга зэрэг эзэлж байх ба зарчмын хувьд харьцуулсан судалгаа, тогтоол батлах болсон хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон суурь үзүүлэлтүүд, тогтоолын хэрэгжилтийг хангуулах богино болон урт хугацааны төлөвлөгөө, хүрэх үр дүнг тоон үзүүлэлтээр оруулах.

4. Тогтоолын төлийн 7.1.2-т “Засгийн газар төрийн мэдлийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжихдаа хөрөнгийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хөрөнгө оруулагчдын сонирхол, санал болгож буй хуулийн этгээдийн үнэ цэн зэрэг хүчин зүйлүүдийг бодитой харгалзан тухайн жилийн жагсаалтыг батлах” гэснийг “Засгийн газар төрийн мэдлийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжихдаа хөрөнгийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хөрөнгө оруулагчдын сонирхол, санал болгож буй хуулийн этгээдийн үнэ цэн зэрэг хүчин зүйлүүдийг бодитой харгалзан тухайн жилийн жагсаалтыг ОУ-ын аудит, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллагын дүгнэлт зөвлөмжид үндэслэн батлах” гэж өөрчлөх саналтай байна. ОУ-ын аудит, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллагаар дүгнэлт зөвлөмж гаргуулах нь тухайн асуудлын бодит байдал, хэмжээг төрийн тусгай байгууллагаас үл хамааран тогтоох боломжийг олгодог ба ОУ-ын стандартыг хэрэгжүүлэхэд нэгдсэн аргачлал, стандартаар үнэлэгдэж, компанийн өөрийн үнэлгээг нэмэгдүүлэх боломжийг бий болгох юм

5. Тогтоолын төслийн 7.1.5-д заасан “Олон нийтийн нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх хуулийн этгээдийг зах зээлийн үнэлгээ, ирээдүйн үнэ цэнийг нарийвчлан тогтоосны үндсэн дээр хэрэгжүүлэх” хэсгийн ирээдүйн үнэ цэнийг нарийвчлан тогтоох шалгуурыг ерөнхий байдлаар оруулах.

6. Төрийн өмчит аж ахуйн нэгжийн хувьцааны хяналтын багц төрийн мэдэлд хэвээр байгаа нөхцөлд тухайн аж ахуйн нэгж санхүүгийн ашиг алдагдал ба Улсын төсвийн харилцан хамаарал ямар түвшинд байхыг тодорхойлох, өөрөөр хэлбэр Улсын төсөвт ачаалал өгөхгүй алдагдлаа өөрөө хариуцах чадварыг дээшлүүлэх зохицуулалтыг хөндөж зарчмын хувьд тусгах.

7. Үндсэн чиглэлийн төсөлд тусгасан төрийн өмчит аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилт нь зөвхөн өмч хувьчлалын үр дүнд биелэгдэх зүйл биш бөгөөд тогтоолоор хувьцааны хяналтын багц төрийн өмчит хадгалагдсан хэвээр байх тул давхар төрийн өмчит аж ахуйн нэгжийн засаглал, удирдлагын мэргэжлийн байдал, томилгооны мерит зарчмыг сайжруулах арга хэмжээ, хөтөлбөрийг тодорхойлох.

8. Агуулгын хувьд тогтоолын төслийн хүрэх үр дүн хэсэгт НҮБ, ЭЗХАБ, ОУБ-уудын сайн засаглалын зарчим, стандарт, удирдамжуудыг баримтлах зарчмыг тусгах хэрэгтэй бөгөөд цаашид төрийн өмчит компаниудын өөрийн үнэ цэнээ өсгөх, зах

зээлийн шударга өрсөлдөөнд амжилттай ажиллаж, эдийн засгийн өсөлт нийгмийн хөгжилд үр өгөөжөө өгөхөд чухал ач холбогдолтой гэж харж байна.

9. Төрийн өмчит аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах асуудлыг үндсэн чиглэлд тодорхой тусгах, ялангуяа Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 85 тоот тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах журам” -ыг шинэчлэх, цаашлаад яамд болон орон нутгийн эрх бүхий байгууллагаас ТУЗ-ийн гишүүдийг томилдог байдлыг таслан зогсоох асуудлыг хөндөх шаардлагатай.

Гүрав. Нээлттэй нийгэм форум НҮТББ: /2025.11.18-ны өдрийн 70 дугаар албан бичиг/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас боловсруулсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэлийн төсөл”-тэй Нээлттэй Нийгэм Форум, түүний дэргэдэх Эдийн засгийн зөвлөл танилцан дараах дүгнэлт, санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэлийн тогтоолын төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу судалгаа, шинжилгээнүүдийг хийх.

Төрийн өмчит компанитай байх эсэх нь тухайн орны геополитикийн онцлогоос ихээхэн хамаардаг. Монгол Улс хоёр том хөрштэй, далайд гарцгүй, том газар нутагтай, цөөн хүн амтай. Иймд төрийн өмчит компани аль салбарт байх нь зохистой талаарх шийдвэрийг УИХ, Засгийн газар нарийн судалгаа, шинжилгээнд үндэслэн гаргах нь зүйтэй байна. Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэлд "МИАТ" ХК, "Монголын цахилгаан холбоо" ХК, "Монголын хөрөнгийн бирж" ХК, "Эрдэнэс таван толгой" ХК, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК, "Дулааны III цахилгаан станц" ТӨХК, "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК "Хөдөө аж ахуйн бирж", "Үндэсний давхар даатгал" ХК гэсэн 9 компанийн тодорхой хэмжээний хувьцааг гаргахаар тусгажээ.

Олон улсад эрчим хүч, тээвэр, харилцаа холбоо, уул уурхайн салбарт төрийн өмчит компани байх нь түгээмэл байна. Манай улсын хувьд эрчим хүчний компаниудыг хувьчлалд хамруулснаар дотоодын эрчим хүчний хангамжийг хэн хариуцах, эрчим хүчний үнэ нэмэгдэх эсэх, хувийн өмчийн оролцоотой эрчим хүчний компаниуд төсвөөс татаас авах эсэх зэрэг асуудлыг сайтар судалсны үндсэн дээр хувьчлах эсэх шийдвэрийг гаргах нь зүйтэй байна. Зайлшгүй төрийн мэдэлд байх салбаруудыг оновчтой тодорхойлж, эрчим хүч, агаарын тээврийн гэх мэт салбарын компаниудыг хувьчилснаар санхүүгийн үзүүлэлтээс гадна улс орны стратегийн хувьд ямар алдагдал хүлээх зэрэг эдгээр асуудлыг судалж, үндсэн чиглэлд тусгах хэрэгтэй юм. Түүнчлэн хувьчлалд хамруулах компани тус бүрээр судалгаа хийж, хувьчлах үндэслэлийг тодорхой гаргах хэрэгтэй юм.

Төрийн өмчит компанийг хувьчлах эсэх шийдвэр нь УИХ-ын тогтоолоор батлагдах тул процесс нь Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу явах, тодруулбал тус хуулийн 8 дугаар зүйлд заасан дараах дарааллаар явах учиртай. Үүнд:

- Холбогдох судалгаа хийх. Хувьчлалын чиглэлээр өмнө хэд хэдэн удаа УИХ-ын тогтоол гарч байсан тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу өмнө тогтоолуудын хэрэгжилт, үр дагаврын үнэлгээг хийх нь зүйтэй. Энэ үнэлгээгээр өмнөх тогтоолуудын хэрэгжилтийн бодит байдал, гарч байгаа хүндрэл

бэрхшээл, эерэг сөрөг нөлөөллийг тогтоосны үндсэн дээр энэ тогтоолоор авах арга хэмжээг тодорхойлно. Энэхүү судалгааны үндсэн дээр Үзэл баримтлал боловсруулахаар хуульд заасан.

- Тогтоолын төслийн хувьд тогтоолын төсөл гарсны дараа түүний нийгэмд үзүүлж болох үр нөлөөг үнэлэх судалгаа хийх, гарч болох зардлыг тооцох ба эдгээр судалгаа хийгдсэний дараа тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу олон нийтэд, холбогдох талуудаар хэлэлцүүлсний үндсэн дээр эцэслэж өргөн мэдүүлэхээр мөн хуульд заасан.

2. Өмнөх хувьчлалын төлөвлөгөөнд туссан боловч хэрэгжээгүй арга хэмжээнүүдийн хувьд хэрэгжээгүй нөхцөл, шалтгаанд үнэлэлт дүгнэлт хийсний дараа хувьчлалын дараагийн чиглэлийг боловсруулах.

Төрийн өмчийг хувьчлах ажлыг Монгол Улс хэд хэдэн үе шаттай хэрэгжүүлсэн. Иймд өмнө хэрэгжүүлсэн хувьчлалын хэрэгжилтийн байдал, хэрэгжсэн хөтөлбөрийн үр нөлөө, хувьчлал нь төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулсан эсэх, компанийн үр ашиг нь нэмэгдсэн эсэх зэрэгт судалгаа, дүгнэлт хийж, УИХ-аар хэлэлцүүлсний дараа хувьчлалын шинэ чиглэлийг боловсруулах нь төрийн өмчийн хувьчлалын үр нөлөөг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм. Түүнчлэн өмнө хэрэгжүүлсэн хувьчлалын хөтөлбөрүүдийн зорилтыг хангаагүй тохиолдолд зохих хариуцлагыг тооцох нь зүйтэй юм.

3. Хувьчлалын зорилгыг нарийвчлан тодорхойлох.

Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэлийн зорилгыг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу нарийвчилсан судалгааны үндсэн дээр сайжруулах нь зүйтэй байна. Үндсэн чиглэлийн зорилгыг "Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулах, төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангахад оршино" хэмээн тодорхойлжээ. Энэ хүрээнд "МИАТ" ХК, "Монголын цахилгаан холбоо" ХК, "Монголын хөрөнгийн бирж" ХК, "Эрдэнэс таван толгой" ХК, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК, "Дулааны III цахилгаан станц" ТӨХК, "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК "Хөдөө аж ахуйн бирж", "Үндэсний давхар даатгал" ХК-ийн тодорхой хэмжээний хувьцааг гаргахаар тусгажээ. Төрийн өмчийг хувьчлах ажлыг хэрэгжүүлснээр төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, үр ашиг нь нэмэгдэх эсэхийг судлах хэрэгтэй юм. Манай улсын татварын орлого ДНБ-ий 34.2 хувьд хүрч, төсвийн зарлага 30 их наяд төгрөг давсан нь зах зээлийн механизм, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд ачаалал үүсгэж байна. Иймд Монгол Улсын эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах нэг арга хэрэгсэл нь татварыг бууруулах явдал юм. Иймд Үндсэн чиглэлд тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлснээр үнэхээр эдгээр зорилгыг хангах эсэхэд нарийвчилсан үнэлэлт, дүгнэлт өгч, зорилгыг бодитоор томьёолох нь зүйтэй байна.

4. Төрийн өмчийн хувьчлал, төрийн өмчит компанийн удирдлага, жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашиг зэрэгт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн шаардлагатай нэмэлт хууль, эрхзүйн орчин бүрдүүлсний дараа өмч хувьчлалын хөтөлбөр хэрэгжүүлэх. Өнөөгийн байдлаар олон тооны төрийн өмчит компани алдагдалтай ажиллаж байна. Практик дээр яамд төрийн өмчит компаниудын

хувьцаа эзэмшигч биш боловч тэдгээр компанид чиглэл өгч удирддаг, яамд хариуцлага хүлээдэггүй байдал бий болоод байна. Иймд төрийн өмчит компаниудын засаглалын асуудлыг цэгцлэх нь зүйтэй байна. Хувьцаат компаниуд шийдвэр гаргахдаа жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийг зөрчиж байгаа асуудлыг зогсоох шаардлагатай байна.

5.Зарчмын хувьд эхний ээлжид төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэлд хувьчлал явуулах салбарыг тусган хэлэлцэн баталсны дараа хувьчлах төрийн өмчийн компанийн жагсаалтыг хэлэлцэн тусад нь батлах. Далайд гарцгүй, хоёр том хөрштэй, том газар нутагтай, цөөн хүн амтай, хүн ам нь тархмал суурьшсан манай улсын хувьд төрийн өмчит компани аль салбарт байх нь зохистой талаарх шийдвэрийг нарийн судалгаа, шинжилгээнд үндэслэн гаргах нь зүйтэй байна. Иймд зайлшгүй төрийн мэдэлд байх салбарууд, хувьчлах салбаруудыг оновчтой тодорхойлж, баталсны дараа хувьчлалд хамруулах компани тус бүрээр судалгаа хийж, хувьчлах шийдвэрийг гаргах нь зүйтэй байна.


6.Төрийн өмчит компанийг хувьчилснаар түүний мэдээллийн ил тод байдал буурах эрсдэлтэйг анхаарах. Шилэн дансны тухай хууль хэрэгжсэнээр төрийн өмчит компанийн мэдээллийн ил тод байдал сайжирсан. Гэвч хувийн хөрөнгө оруулалтын оролцоотой болсноор төрийн өмчит компанийн мэдээллийн ил тод байдал буурах эрсдэлтэй тул холбогдох зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.



Төсөл / Зурвардээ

ТӨРИЙН ӨМЧИЙГ ХУВЬЧЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХУВЬЦААГ 2025-2028 ОНД БИРЖЭЭР ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХУДАЛДАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛД ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН САНАЛ АВЧ БАЙНА.

26



СУУД НЭМЭГДЭСЭН

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, халтсийн дарга нарын иргэдийг хүлээн авч уулзах хуваарь

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, халтсийн дарга нарын иргэдийг хүлээн авч уулзах хуваарь

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН 1 ДАВХАРТ 50 МЕТР КВАДРАТБҮХИЙ ТАЛБАЙГ КОФЕ ШОПИЙН ЗОРИУЛАЛТААР ТҮРЭЭСЛЭХ ТАЛБАЙН

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЗҮҮН БАЙРНЫ 1 ДАВХАРТ 36

26 responses to "ТӨРИЙН ӨМЧИЙГ ХУВЬЧЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХУВЬЦААГ 2025-2028 ОНД БИРЖЭЭР ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХУДАЛДАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛД ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН САНАЛ АВЧ БАЙНА."

Зочин
2025-01-11
Үндсэн чиглэлд ороогүй бусад хуулийн этгээдүүдээс нэмэх боломжтой юу. Өмнөх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд үнэлэлт өгсөн үү. МИАТ, Эрдэнэс таван толгой зэрэг компаниудыг сруулж ирсэн байна. дэмжиж байна. Цаашид Эрдэнэт, Эрдэнэс монгол, Багануур, ТЭЦ-4 зэрэг компаниудыг нээлттэй компани болгох хэрэгтэй гэж үзэж байна.

Батл

Бсдбаатар
2025-01-11
Маш зөв 100% дэмжиж байна

Батл

Лханаа
2025-01-11
Дэмжиж байна


Батл

Батаа
2025-01-11
Дэмжиж байна

Батл

Од
2025-01-11
Demj бна

Батл



"Монголын төмөр зам" ТӨХХ-ийн Гүйцэтгэх захирал О.Батмөнх "Орхон-Өвөрхангай үндэсний аймаг" хамгааллын Мэдээллийн технологийн газартай Хийм Сан-Бичиглэл" Read More



"Монгол-Оросын харилцаа 100 жилд" Олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд оролцлоо Read More



Төрийн өмчийн газартай Хийм Сан-Бичиглэл – IPO Read More

Demji bn

Reply



Дээгий

2025-11-11

Дэмжиж байна

Reply



Батсолонго

2025-11-11

Дэмжиж байна.

Reply



zochin

2025-11-11

Хувьчлах нь зөв өө. Дэмжиж байна.

Reply



Амарраа

2025-11-11

Дэмжиж байна.

Reply



Delger

2025-11-11

Санал өгсөн

Reply



Одончимэг

Улсын Их Хурлын “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг боловсруулах
Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

1. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын С.Бямбацогт
2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Ш.Раднаасэд
3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн
4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл
5. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын Засгийн газрын ахлах референт Д.Нямдэлгэр
6. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий,
7. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох,
8. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран,
9. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн,
10. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ
11. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар
12. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн А.Молор
13. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт,
14. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Чинбат,
15. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Отгонбаяр,
16. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жавхлант,
17. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат
18. “Хөдөө аж ахуйн корпораци” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Цогтсаран,
19. “МИАТ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Т.Тэлмэн
20. “МИАТ” ТӨХК-ийн Санхүү удирдлагын газрын захирал Н.Цэгц
21. “Төрийн банк” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ө.Гантөр
22. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Н.Цэрэнсамбуу,
23. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн Захирал Г.Ёндон,
24. “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ийн Захирал Д.Тогтохсүрэн,
25. “Дулааны III цахилгаан станц” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Сандуйжав,
26. “Дулааны IV цахилгаан станц” ХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Тавинбэх,
27. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бат-Эрдэнэ,
28. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайхан,
29. “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал М.Жаргалсайхан,
30. “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал М.Мөнхөө,
31. “Шивээ овоо” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин,
32. “Багануур” ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Түвшинжаргал
33. “Дулаан шарын гол” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал П.Баярцэцэг,
34. “Цемент шохой” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Баттүвшин,
35. “Монгол шуудан” ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн

36. "Багануур дулааны станц" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ариун-Эрдэнэ
37. "Налайхын дулаан станц" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин,
38. "Хөвсгөл дулааны станц" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал П.Санлигрэнчин
39. "Ховд дулааны станц" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Энхсайхан,
40. "Улаангомын дулааны II станц" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Анхбаяр